



АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ БА ШУДАРГА
БАЙДЛЫН АЛБА

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ (2015)

АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ БА ШУДАРГА
БАЙДЛЫН АЛБА

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ (2015)



Криэйтив Коммонс
Дугаар – Худалдааны бус – 3.0
IGO лиценз(CC BY-NC-ND 3.0 IGO)

© 2015 Азийн Хөгжлийн Банк
6 АХБ-ны өргөн чөлөө, Мандалуёонг хот, 1550 Метро Манила, Филиппин
Утас +63 2 632 4444; Факс +63 2 636 2444
www.adb.org; openaccess.adb.org
OARsupport@adb.org; publications@adb.org

Зарим эрхийг хамгаалав. 2015 онд хэвлэгдсэн.
Филиппин улсад хэвлэв.

ISBN 978-92-9257-222-8 (хэвлэмэл), 978-92-9257-223-5 (цахим-ISBN)
Хэвлэлийн дугаар. TIM157125

Энэхүү зааварт тусгагдсан үзэл бодол нь зөвхөн зохиогчдын үзэл бодол бөгөөд Азийн Хөгжлийн Банк (АХБ), түүний Захирлуудын зөвлөл, зохиогчдын төлөөлж буй засгийн газруудын үзэл санаа, бодлогыг заавал илэрхийлэх албагүй. Энэ зааварт тухайн газар нутаг эсвэл газар зүйн нутаг дэвсгэрийг дурьдахдаа эсвэл “улс орон” гэсэн нэр томъёог ашиглахдаа АХБ нь аливаа газар нутаг, нутаг дэвсгэрийн эрх зүйн болон бусад статусын талаар шүүмж гаргахыг зориогүй болно.

Энэхүү ном нь Криэйтив Коммонсийн харьяан дээр байна : худалдааны бус - This work is available under the Creative Commons Attribution- NoDerivs 3.0 IGO лицензний дугаар (CC BY-NC-ND 3.0 IGO) <http://creativecommons.org/licenses/by-nc-nd/3.0/igo/>. Энэхүү номны агуулгыг ашиглахдаа энэхүү лицензний нөхцлийг даган мөрдөх болон openaccess.adb.org/termsfuse хаягтай АХБ-ны Нээлттэй номын сан Үйлчилгээний нөхцлийг дагахыг хүлээн зөвшөөрч байгаа болно.

КК лиценз нь энэхүү номны АХБ-ны бус зохиогчийн эрхтэй материалд хамаарахгүй.

Тэмдэглэл: Энэ зааварт (i) “\$” тэмдэг нь ам.долларыг илэрхийлнэ.

Contents

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА АРГАЧЛАЛ (2015 оны 1-р сар)*

I. ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ ХЯНАЛТ ШАЛГАЛТАНД БАРИМТАЛДАГ ЗАРЧМУУД БА АРГАЧЛАЛ	1
УДИРТГАЛ	1
ЕРӨНХИЙ ЗАРЧМУУД	3
ТОДОРХОЙЛОЛТ	17
ЭРХ БА ҮҮРЭГ	19
АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ	28
ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ЦУГЛУУЛСАН МЭДЭЭЛЭЛ	34
ТУХАЙН УЛСЫН АЛБАДАД ЛАВЛАГАА ӨГӨХ	35
ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ	35
ХЭВЛЭН НИЙТЛЭХ	35
II. ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ	36
ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ҮНДЭСЛЭЛ	36
ЭРЭН СУРВАЛЖЛАХ АЖИЛЛАГААНД	
ХАМРУУЛАХ ТАЛААР ТАЛУУДАД МЭДЭГДЭХ	38
ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ	42

* Энэхүү товхимлыг нь 2006 онд гарсан, 2012 онд шинэчилэгдсэн Шударга байдлын зарчмууд ба удирдамжийн оронд хэрэглэнэ.

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

АХБ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ЭРХИЙГ ХАСАХ ХУГАЦАА	53
ЗАРГА МЭДҮҮЛЭХ	59
ЭРХИЙГ СЭРГЭЭХ	62
ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ	65
ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ХАР ДАНСАНД ОРУУЛАХ	66

АХБ-ны Орчуулсан баримт бичгийн тухай тайлбар

Энэхүү баримт бичгийг олон нийтэд хүртээмжтэй болгох зорилгоор Англи хэлнээс орчуулав. Азийн Хөгжлийн Банк нь орчуулгын үнэн зөвийг хянасан боловч АХБ-ны албан ёсны хэл нь Англи хэл тул энэхүү баримт бичгийн Англи хэл дээрх хувийг жинхэнэ (энэ нь албан ёсны бүрэн эрхэт) эх хувь гэж үзнэ. Энэхүү баримт бичгээс ишлэл татахдаа Англи хэл дээрх эх хувийг заавал дурдвал зохино.

I. ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ ХЯНАЛТ ШАЛГАЛТАНД БАРИМТАЛДАГ ЗАРЧМУУД БА АРГАЧЛАЛ¹

УДИРТГАЛ

Доорхи байгууллагууд өөрсдийн эрэн сурвалжлах нэгжүүдээр дамжуулан эрэн сурвалжлах хяналт шалгалтанд баримтлах ерөнхий зарчмууд ба аргачлалыг хамтран баталсан:

- Африкийн Хөгжлийн Банкны Групп
- Азийн Хөгжлийн Банк
- Европын Сэргээн босголт Хөгжлийн Банк

¹ Дээр жагсаасан Олон улсын санхүүгийн байгууллагуудын эрэн сурвалжлах зарчмууд ба аргачлалыг энэ Шударга байдлын зарчмууд ба аргачлалын 1-р Бүлэгт оруулж өгсөн ба Азийн хөгжлийн банк (АХБ)-нд хамаарах бүлгүүдийг тусгайлан түүвэрлэн оруулсан болно.

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

- Европын Хөрөнгө оруулалтын Банкны Групп
- Америк дундын Хөгжлийн Банкны Групп
- Дэлхийн Банкны Групп

Тухайн банкны байгууллагын хүрээнд мөрддөг бодлого, дүрэм журам, зохицуулалт, эрх мэдэл ба халдашгүй байдалтай уялдуудан эдгээр зарчмуудыг эрэн сурвалжлах ажиллагааг явуулахад мөрдлөг болгон ашиглана.²

АХБ: Эдгээр зарчмууд ба аргачлалыг Авилгатай тэмцэх ба Шударга байдлын алба (АТШБА), түүний ажилтанууд, эсвэл АТШБА-ны гүйцэтгэх ёстой эрэн сурвалжлах ажлыг гүйцэтгэх эрхийг төлөөлөн олгосон болон Ерөнхийлөгчийн томилсон талууд, түүнчлэн АХБ-ны бүх ажилтанууд мөн АХБ-ны холбоотой үйл ажиллагаанд³ оролцож буй АХБ-ны хөлслөн ажиллуулж буй Зөвлөхүүд, гүйцэтгэгчид болон гуравдагч талууд Авилгын эсрэг Бодлогыг хэрэгжүүлэхдээ⁴ баримтлах ёстой.

² Эдгээр аргачлал нь Эрэн сурвалжлах ажиллагааг явуулж буй байгууллагын захиргааны үйл ажиллагаа болон хуулийн хүрээнд аливаа нэмэлт эрх, үүргийг олгохгүй. Аргачлалын ямар ч зүйл анги нь Тухайн байгууллагад олон улсын гэрээгээр болон тухайн улсын хуулиар олгогдсон дүрэм, бодлого ба үйл ажиллагаа, эрх мэдэл, халдашгүй байдалтай холбоотой эрх үүрэгт нөлөөлнө гэсэн тайлбар байх ёсгүй.

³ "АХБ-ны ажиллагаатай холбоотой үйл ажиллагааг 1.С-д тодорхойлов, *Дэд бүтэц*.

⁴ Зөвлөлийн тайлан R-89-98, Авилгын эсрэг Бодлого, 1998 оны 7-р сарын 2-нд батлагдсан, Зөвлөлийн тайлан R185-04-аар тодотгол хийгдсэн, Авилгын эсрэг Бодлого: Зөвлөх болон Худалдан авалтын удирдамжтай холбогдуулан гаргаж

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ...

Энэхүү баримт бичгийн зориулалтаар ашиглаж буй “Байгууллага” гэдэг нэр томъёонд дээр дурьдсан банкны байгууллагуудын салбар хэсэг болон тэдгээртэй холбоотой бүх байгууллагуудыг ойлгоно. Тухайн байгууллага тус бүрийн эрэн сурвалжлах нэгжийг “Эрэн сурвалжлах алба” гэж ойлгоно.

ЕРӨНХИЙ ЗАРЧМУУД

1. Байгууллага бүр эрэн сурвалжлах ажлыг гүйцэтгэх Эрэн сурвалжлах албатай байна.

АХБ: 1.А. АТШБА нь АХБ-ны холбоотой үйл ажиллагаа болон АХБ-ны ажилтануудын оролцсон шударга байдлын зөрчлийн тохиолдлын мэдээллийг анхлан хүлээн авах цэг бөгөөд Эрэн сурвалжлах алба юм.

1.В. “Шударга байдлын зөрчил” гэж АХБ-ны Авилгатай тэмцэх Бодлогыг зөрчсөн аливаа үйлдлийг тооцох ба үүнд авилга, залилан, тулган шаардалт, нууцаар үгсэн хуйвалдаан, албан тушаалаа урвуулан ашиглалт, ашиг

үргэлжлэл дараагийн нүүрэнд

буй тодрулга хийх санал ба холбогдох өөрчлөлтүүд, 2004 оны 11-р сарын 11-нд батлагдсан, ба Зөвлөлийн тайлан R179-06, Авилгын эсрэг Бодлого: Авилга болон залилан мэхлэх зөрчлийн нэгдсэн нэр томъёо, 2006 оны 9-р сарын 8-нд батлагдсан.

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

үргэлжлэл

сонирхолын зөрчил⁵ ба саад учруулах зэрэг үйлдлүүд хамаарна.

1.C. “АХБ-ны холбоотой үйл ажиллагаа” гэдэгт АХБ-ны санхүүжүүлж байгаа, хариуцан хэрэгжүүлж байгаа болон дэмжлэгтэйгээр хэрэгжиж байгаа үйл ажиллагаа болон эд хөрөнгийн нөлөө нь АХБ-ны эрх ашгийг шууд хөндөх эс бөгөөс АХБ-нд ямар нэгэн байдлаар хамаарах үйл ажиллагаа багтана.

1.D. “Олон улсын хар дансанд оруулах” гэж АХБ болон бусад Оролцогч банкны байгууллагуудын зүгээс тавьсан Хориг арга хэмжээ авах шийдвэрийг харилцан уялдаатай албадан хэрэгжүүлэх тухай Хэлэлцээр бөгөөд энэ нь Оролцогч банкны байгууллага бусад банкны байгууллагаас авилга, залилан, тулган шаардалт, үгсэн хуйвалдах зөрчилд оногдуулж олон нийтэд зарласан хориг арга хэмжээний шийтгэлийг Хэлэлцээрт нэгдсэн байгууллагууд нэг адил албадан хэрэгжүүлэхийг ойлгоно.

үргэлжлэл дараагийн нүүрэнд

⁵ Аливаа ашиг сонирхолын зөрчил (АСЗ) нь Шударга байдлын зөрчил гэж зайлшгүй тооцогдохгүй байж болно.

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ...

үргэлжлэл

1.Е. “Оролцогч байгууллагууд” гэж Олон улсын хар дансанд оруулах Хэлэлцээрт нэгдэж гарын үсэг зурсан болон Олон улсын хар дансанд оруулах Хэлэлцээрт цаашид нэгдэх бүх талыг ойлгоно.⁶

2. Эрэн сурвалжлах албаны гүйцэтгэх хяналт шалгалтын ажиллагааны зорилго нь тухайн байгууллагын хүрээнд тодорхойлсон авилга болон залилан мэхлэх зөрчил илэрсэн эсэх нөхцөл байдлыг шалган тогтоох явдал бөгөөд энэ шалгалт нь Тухайн байгууллагын санхүүжүүлж буй төслүүд болон тухайн байгууллагын албан тушаалаа буруугаар ашиглах зөрчил гаргасан байж болзошгүй ажилтнууд ба эдгээрээр хязгаарлагдахгүй нөхцөл байдлыг хамран хийгдэнэ.

АХБ: 2.А. Дараах зөрчилүүд илэрсэн тохиолдолд АТШБА-аас эрэн сурвалжлах үйл ажиллагааг явуулах магадлалтай:

үргэлжлэл дараагийн нүүрэнд

⁶ Африкийн Хөгжлийн банкны Групп, АХБ, Европын Сэргээн босголт, Хөгжлийн Банк, Америк дундын Хөгжлийн Банкны Групп, Дэлхийн Банк анхлан нэгдсэн. Олон улсын хар дансанд оруулах Хэлэлцээрийн дагуу Оролцогч байгууллагууд санал нэгдэн дэмжсэн тохиолдолд олон улсын бусад санхүүгийн байгууллагууд хэлэлцээрт нэгдэж болохоор заасан.

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

үргэлжлэл

- i. Авилга гэж нөгөө талын үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөхийн тулд аливаа үнэ бүхий зүйлийг шууд болон шууд бус хэлбэрээр өгөхийг санал болгох, өгөх, хүлээн авах, өгөхийг шаардахыг хэлнэ.
- ii. Луйвар гэж аливаа тал хүлээсэн үүргээсээ зайлсхийх эсвэл санхүүгийн болон бусад ашиг олохын тулд санаатай болон санаандгүйгээр төөрөлдүүлэх, төөрөлдүүлэхийг оролдох зэрэг үйлдэл хийгээд хайхрамжгүй алдааг хэлнэ.
- iii. Тулган шаардалт гэж нөгөө талын үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөхийн тулд аливаа хохирол болон гэмтлийг шууд болон шууд бус хэлбэрээр учруулахыг болон учруулахаар заналхийхийг хэлнэ.
- iv. Нууцаар үгсэн хуйвалдах гэж Нөгөө талын үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх зэрэг байдлаар хууль бус зорилгод хүрэхийн тулд 2 ба түүнээс дээш талуудын хамтран хийсэн далд тохиролцоог хэлнэ;⁷

үргэлжлэл дараагийн нүүрэнд

⁷ АХБ-ны Захирлуудын зөвлөлийн R179-06 албан бичгээр авилга, залилан, тулган шаардалт болон үгсэн хуйвалдахын тодорхойлолтыг олон улсын хөгжлийн Банкнуудын тодорхойлолттой ижилтгэн нийцүүлсэн.

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ...**үргэлжлэл**

- v. Зүй бусаар ашиглах гэж АХБ-ны оролцоотой үйл ажиллагаатай холбоотой өмч хөрөнгийг санаатайгаар болон хайхрамжгүй байдлын улмаас хулгайлах, үрэгдүүлэх зориулалтын бусаар ашиглахыг хэлнэ;
- vi. Ашиг сонирхолын зөрчил гэж аливаа талын албан үүргээ гүйцэтгэх, гэрээний үүргээ биелүүлэх болон холбогдох хууль журмын дагуу ажиллах явцад зүй бусаар нөлөөлж болохуйц далд сонирхол агуулагдсан аливаа нөхцөл байдлыг хэлнэ;
- vii. Саад учруулах гэж (а) Хяналт шалгалтын нотолгоо болохуйц материал ба мэдээллийг санаатайгаар устгах, худал мэдээлэх, өөрчлөх болон нуун дарагдуулах (б) АХБ-ны мөрдөн шалгах үйл ажиллагаанд бодит саад учруулах зорилгоор асуудлыг шалгаж байгаа мөрдөгчид худал мэдүүлэг өгөх; (в) АТШБА-ны хяналт шалгалттай холбоотой мэдээлэл, баримт бичиг болон бүртгэлийг гаргаж өгөх хүсэлтийг биелүүлж чадаагүй; (г) тухайн мөрдөн байцаах ажилтай холбоотой мэдээллийг мэдэж байгаа хүн өөрийг нь илчлэхээс сэргийлж

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

үргэлжлэл

бусдыг айлган сүрдүүлэх, дарамтлах болон заналхийлэх; (д) АХБ-ны гэрээгээр хүлээсэн Аудитын шалгалт хийх болон мэдээлэл олж авах ажиллагаанд бодит саад учруулахыг хэлнэ.

- viii. АХБ-ны хориг арга хэмжээг зөрчих;
- ix. Мэдүүлэгч болон гэрчээс өс хонзон авах оролдлогууд; үүнд шууд болон шууд бус байдлаар гэмтэл учруулах, заналхийлэх, айлган сүрдүүлэх эсвэл эдгээрийг зөвхөн мэдүүлэгч болон гэрчид бус мэдүүлэгч болон гэрчтэй холбоотой хүмүүст дарамт хэлбэрээр үзүүлэх, мэдүүлэгч болон гэрч АХБ-ны хяналт шалгалтын үйл ажиллагаанд орсонтой уялдан гарч ирэх аливаа гомдол зэргийг Захиргааны Журам (ЗЖ)-ын 2.10-р;⁸ заалтын дагуу эрэн сурвалжилж асуудлыг шийднэ.
- x. АХБ-ны Авилгын эсрэг Бодлогын бусад зөрчилд ёс зүйн хэм хэмжээг баримтлаагүй зөрчлүүд багтана.

үргэлжлэл дараагийн нүүрэнд

⁸ Мэдээлэгч ба Гэрчийг хамгаалах.

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ...

үргэлжлэл

2.В. Хяналт шалгалтаар мөн шударга байдлыг зөрчихөөр завдсан болон энэ үйлдэлд сэжиглэж буй тохиолдлыг хамруулж болно.

2.С. АХБ-ны ажилтнууд албан тушаалын гэмт хэрэгт холбогдож шударга байдлын зөрчил гаргасан болон Мэдээлэгч болон гэрчийн эсрэг дарамт шахалт үзүүлсэн зөрчлийг Шударга байдлын Зарчмууд ба Аргачлалын 2-р Хавсралт болон ЗЖ-ын 2.04⁹, ба ЗЖ-ын 2.10-р заалтын дагуу хянан шалгана.

2.Д. АТШБА-наас ЗЖ-ын 2.04-р заалтын дагуу Ерөнхийлөгчийн болон Төсөв, Боловсон хүчин, Менежментийн системийн Газар (ТБХМСГ)-ын даргын хүсэлтээр албан тушаал урвуулан ашигласан бусад зөрчлийг мөн хянан шалгаж болно.

үргэлжлэл дараагийн нүүрэнд

3. Эрэн сурвалжлах алба нь хяналт шалгалтын ажлын явцад үнэн зөв дүгнэлтийг хийж, алагчлалгүй, шударга байж хяналт шалгалтын ажиллагааг зохих шаардлагад нийцүүлэн ёс зүйн өндөр түвшинд гүйцэтгэх ёстой. Ялангуяа Эрэн сурвалжлах алба нь өөрийн үүргээ үйл ажиллагаа хариуцсан болон оролцдог талууд болон

⁹ Салхилгын арга хэмжээ ба журам.

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

хяналт шалгалтанд сэжигтэнээр тооцогдсон ажилтанууд, зохисгүй нөлөөлөл болон дарамт шахалтаас ангид явуулах ёстой.

4. Эрэн сурвалжлах албаны ажилтан нь өөрийн оролцох гэж буй хяналт шалгалттай холбоотой бодит болон болзошгүй ашиг сонирхолын зөрчил өөрт нь байвал удирдлагадаа цаг алдалгүй мэдэгдэх ёстой ба удирдлага нь тухайн зөрчлийг арилгах тохирох арга хэмжээг авна.

АХБ: 4.А. Ашиг сонирхолын зөрчлийг АТШБА-ны даргад эсвэл тухайн ажилтан өөрийн шууд хариуцсан удирдлагадаа тухайн нөхцөл үүссэн даруй ба аливаа хяналт шалгалтын ажил эхлэхээс өмнө мэдэгдэнэ. АТШБА-ны даргын оролцсон ашиг сонирхолын зөрчлийг Ерөнхийлөгчид мэдэгдэнэ. Ашиг сонирхолын зөрчлийг зохицуулах аливаа арга хэмжээ нь бичгээр байна. Ашиг сонирхолын зөрчлийг арилгах аргуудад тухайн хүнийг хяналт шалгалтын ажлаас татгалзуулах, тухайн хэрэгтэй холбоотой бүртгэл болон мэдээлэлтэй танилцах хүрээг хязгаарлах болон эдгээрээр хязгаарлагдахгүй бусад арга хэмжээнүүд багтана.

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ...

5. Эрэн сурвалжлах албаны ажилтантай холбоотой албан тушаалын гэмт хэргийг эрэн сурвалжлах тохирох журмыг бэлтгэн бэлэн байлгах ёстой.

АХБ: 5.А. АТШБА болон ТБХМСГ-ын удирдах ажилтны оролцсон албан тушаалын хэрэг болон шударга байдлын зөрчлийн тохиолдлыг Захиргаа, компанийн удирдлага хариуцсан Дэд ерөнхийлөгчид ЗЖ-ын 2.10, ба 4.3-р заалтын дагуу мэдэгдэнэ.

5.В. Аль нэг Дэд ерөнхийлөгчийн оролцсон албан тушаалын хэрэг болон шударга байдлын зөрчлийн тохиолдлыг Ерөнхийлөгчид ЗЖ-ын 2.10 ба 4.4 заалтуудын дагуу мэдэгдэнэ.

5.С. АТШБА-ны ажилчид, зөвлөхүүд болон гүйцэтгэгчдийн оролцсон албан тушаалын хэрэг болон шударга байдлын зөрчлийн тохиолдлыг АТШБА-ны тэргүүн болон Даргад шууд мэдэгдэнэ.

6. Байгууллага бүр өөрийн Эрэн сурвалжлах албаны мандат эсвэл эрхлэх ажил үүргийн хүрээ болон өөрийн Эрэн сурвалжлах албаны шударга байдлын төлөө, залилан болон авилгын эсрэг хийсэн үйл ажиллагааны жилийн тайланг өөрийн бодлого болон мэдээллийг түгээх журмын дагуу хэвлэн нийтлэх ёстой.

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

АХБ: 6.В. Ажил үүргийн хуваарийн дагуу АТШБА-ны дарга нь Ерөнхийлөгчид ажлаа шууд тайлагнана. Тэрээр ажлаа Ерөнхийлөгчид шууд, АТШБА-ны голлох үйл ажиллагаа болон үр дүнгийн талаар Ерөнхийлөгчөөр дамжуулан Захиралуудын Зөвлөлийн Аудитын хороонд ажлаа танилцуулдаг. АТШБА-ны үйл ажиллагааг эрхлэн явуулахдаа АТШБА-ны дарга болон эрх бүхий ажилтанууд нь АХБ-ны үйл ажиллагаа, боловсон хүчин болон бодит хөрөнгийн талаархи мэдээлэл бүртгэлтэй саадгүй танилцах, шаардлагатай тохиолдолд тэдгээр мэдээллийг түр хугацаагаар эзэмшин холбогдох хяналтыг хийх эрхийг эдэлнэ. АТШБА-ны үндсэн үүргүүд нь

- Холбогдох газар/хэлтэстэй хамтран ажиллаж АХБ-ны Авилгын эсрэг бодлогын талаархи мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх.
- Бусад газар/хэлтэстэй зөвлөлдөн Авилгатай тэмцэх бодлогын хүрээнд банкны бүх ажилтан болон төслүүд авилгын эсрэг байж шударга байдлын өндөр стандартыг хангахад шаардлагатай үйл ажиллагааг хянаж, санал болгох.

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ...

үргэлжлэл

- АХБ-ны шударга байдлын зөрчлийг тодорхойлж өгсөн 2.А-р заалтын дагуу АХБ-ны аливаа үйл ажиллагаа болон түүний ажилтантай холбогдон гарсан шударга байдлын зөрчлийн мэдээллийг анхлан хүлээн авах цэгийн үүргийг гүйцэтгэнэ.
- АТШБА-ны хүрээнд баримталж буй болон тодорхойлсон АХБ-ны Авилгын эсрэг бодлогын хүрээнд шударга байдлын зөрчлүүдэд бие даасан, үнэн зөв хяналт шалгалтыг явуулах.
- АХБ-ны санхүүжилттэй үйл ажиллагаанд төслийн худалдан авалттай холбоотой хяналт шалгалтыг хийж шударга байдлын зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх болон илрүүлэх.
- Эдгээр шударга байдлын зарчмууд ба аргачлалд зохицуулсан байдалд хамааралтай хяналт шалгалтын явцад илрүүлсэн мэдээллийг гаргаж өгөх.
- Эрэн сурвалжлах хяналт шалгалтыг явуулахдаа Менежментийн Алба, Хуулийн Ерөнхий Зөвлөхийн Алба (ХЕЗА), ТБХМСГ ба бусад газар/хэлтэстэй хамтран ажиллаж

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

үргэлжлэл

шударга байдлын зөрчил тохиолдсон эсэхийг тогтоох, холбогдох нотолгоо материалыг цаашид цуглуулах, гэмт хэрэгтэнийг тогтооход баримтлах зарчмын алхамууд, зөрчлийн ноцтой байдал, ашигласан техник болон зөрчил гарах болсон шалтгаан, эдгээр зөрчилд өртөх нөхцөл байдлыг бууруулахад ашиглаж болох хяналтын арга хэмжээг тодорхойлох болон иймэрхүү төрлийн залилан, авилга болон албан тушаал урвуулан ашиглах зөрчлийг илрүүлэхэд дэм болохуйц механизмыг бий болгох.

- АХБ-ны ажилтанууд албан тушаалын гэмт хэрэгт холбогдож шударга байдлын эсрэг гаргасан зөрчлийг Шударга байдлын Зарчмууд ба Удирдамж болон ЗЖ-ын 2.04-р заалтын 2-р Хавсралтын дагуу хянан шалгана.
- ЗЖ 2.04-ын дагуу Хүний нөөцийн хэлтсээс мэдүүлсэн албан тушаал урвуулан ашигласан байж болзошгүй зөрчлийн мэдээллийг хянан шалгах.
- Өөрийн үйл ажиллагааг нэгтгэн дүгнэсэн жилийн тайланг бэлтгэж Ерөнхийлөгчид хүргүүлэх.

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ...

үргэлжлэл

- Олон талт хөгжлийн банкууд, олон улсын санхүүгийн байгууллагууд болон бусад холбогдох талуудтай Шударга байдлын зөрчлийн асуудлыг банкны дотоодод болон гадна талд хамгийн үр дүнтэйгээр хэрхэн авч үзэх талаар санал бодол, бодит туршлага солилцох, ойлголтыг бататгах чиглэлд зөвлөлдөж хамтран ажиллах.
- Гүйцэтгэх удирдлага болон холбогдох газар хэлтсүүдэд Шударга байдал болон мөнгө угаах/терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдох асуудлууд, үүн дотор ноцтой асуудал мөн эсэхийг үнэлж дүгнэх боломжийг АХБ-д олгох эрэн сурвалжлах хяналт шалгалтын талаар хараат бус зөвлөгөө өгөх.
- Шударга байдал, мөнгө угаах/терроризмыг санхүүжүүлэхтэй холбогдох эрсдэлүүд болон шударга байдлын шинжилгээ, үүн дотор мөнгө угаах/терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа явагдаж байгаа эсэхийг тогтоох ажилбарын талаар холбогдох газар хэлтсүүдэд зааж зөвлөх.

7. Эрэн сурвалжлах алба нь хяналт шалгалтын ажилтай холбоотой олон нийтэд мэдээлэх ёсгүй мэдээллийн нууцлалыг хадгалах тодорхой арга хэмжээг

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

авах ёстой ба үүнд хяналт шалгалтанд татагдан орж буй талууд болон гэрчийн мэдүүлэг болон нотлох баримт танилцуулж буй талуудын хувийн мэдээллүүд багтана. Тухайн байгууллагын хүрээнд бүх мэдээллийг хадгалах болон холбогдох талуудад; үүнд байгууллагын доторхи талууд болон гадны байгууллагууд (тухайн улсын үндэсний албадад) ашиглуулах арга хэлбэр нь тухайн байгууллагын дүрэм журам, бодлого үйл ажиллагааны хүрээнд тогтоогдоно.

АХБ: 7.А. АТШБА нь өөрийн мэдээлэл болон бүртгэлийг зохих бодит, цахим болон журамласан хяналтын дор хадгална. АТШБА-наас тухайн хяналт шалгалтын үндсэн шалтгаан болон сэжигтэн талын хувийн мэдээлэл зэрэг хяналт шалгалттай холбоотой мэдээллийг хуваалцах байдалд хязгаарлалт тавьж зөвхөн тухайн асуудлыг мэдэх ёстой талтай л хуваалцана. Тухайн зөрчлийн онцлогоос хамааран ЗЖ 2.10-ын дагуу мэдээлэгч болон гэрчийг хамгаалах шаардлагыг тооцоолон АТШБА-наас зарим нотолгоо баримтыг хяналт шалгалтанд орж буй талд¹⁰ мэдээлдэг.

үргэлжлэл дараагийн нүүрэнд

¹⁰ Эрэн сурвалжлах хяналт шалгалтын "субъект" гэж АТШБА-аас шалгаж буй шударга байдлын зөрчил ба/эсвэл буруу үйлдлийг хийсэн хэмээн үзэж буй этгээдийг хэлнэ

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ...

үргэлжлэл

7.В. Зөвхөн АТШБА болон Ерөнхийлөгч л АТШБА-ны мэдээлэл болон бүртгэлийн материалыг үзэх эрхтэй. АТШБА болон Ерөнхийлөгч АТШБА-ны мэдээлэл болон бүртгэлийн материалыг ЗЖ-ын 2.04, ба 2.10, Олон нийттэй харилцах Бодлого болон АХБ-ны бусад холбогдох дүрэм журмын дагуу бусад талтай хуваалцах, засварлах эсэхийг тогтооно.

8. Хяналт шалгалтаар цуглуулсан мэдээлэл нь бодит баримт болон холбогдох дүн шинжилгээнд үндэслэсэн байх ёстой ба үүнд нотолгоот дүгнэлтийг багтааж болно.

9. Эрэн сурвалжлах алба нь өөрийн хяналт шалгалтын үр дүнд суурилсан оновчтой зөвлөмжийг тухайн байгууллагын удирдлагад гаргаж өгөх ёстой.

10. Эрэн сурвалжлах албаны явуулах бүх хяналт шалгалт нь захиргааны шинж чанартай байна.

ТОДОРХОЙЛОЛТ

11. Албан тушаалын гэмт хэрэг гэдэг нь тухайн ажилтан байгууллагын тогтоосон дүрэм журам болон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдлийг хэлнэ.

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

АХБ: 11.А. АХБ-ны ёс зүйн баримтлалд мөрдөх хэм хэмжээг ЗЖ-ын 2.02.^{11 12}-р заалтанд харин АХБ-ны албан тушаалын гэмт хэргийн зөрчлийг ЗЖ-ын 2.04-р заалтанд тайлбарласан.

12. Гомдлыг үндэслэлтэй болохыг тогтооход ашиглах стандарт нотолгоог тухайн эрэн сурвалжлах ажлын зориулалтаар тогтоож болох ба тухайн мэдээлэл нь бүхэлдээ эсвэл ямар нэгэн түвшинд зөрчил гарсан тухай нотолгоо нь гараагүй нотолгооноос илүү байх ёстой.

АХБ: 12.А. АХБ энэхүү нотолгооны стандартыг бусад нотолгооноос давамгайлах байдал болгож үзэх, эсвэл тэдгээр нотолгоо нь итгэл үнэмшлийг дэмжиж, холбогдох бүх хүчин зүйлс ба нөхцөл байдлыг тооцоолж зөрчил үүссэн байх магадлалын боломжийг үндэслэн тухайн этгээд шударга байдлын зөрчил гаргасан болохыг эцэслэн тогтооно.

¹¹ Боловсон хүчний бодлогын тайлан ба Ажилтануудын үүрэг ба хариуцлага.

¹² ЗЖ-ын 2.10 (Мэдээлэгч ба Гэрчийг хамгаалах)-ын дагуу өшөө авахыг буруу гэж үзэх бөгөөд ийм үйлдэл хийсэн этгээдэд ЗЖ-ын 2.04-д заасан сахилгын арга хэмжээг ногдуулна.

ЭРХ БА ҮҮРЭГ

Гэрч ба сэжигтэн

13. Байгууллагын дүрэм журам, бодлого болон үйл ажиллагааны дагуу “мэдээлэгч” болох нь тогтоогдсон ажилтанд байгууллагын зүгээс дарамт шахалт тулгаж болохгүй. Дарамт шахалт үзүүлэхийг байгууллагын зүгээс албан тушаалын гэмт хэргийн хэлбэр гэж үзнэ.

АХБ: 13.А. Мэдээлэгч болон гэрчийг хамгаалах асуудлыг ЗЖ-ын 2.10-р заалтаар зохицуулна.

14. Байгууллагын зүгээс өөрийн ажилтануудад залилан, авилга болон албан тушаалын гэмт хэргийн аливаа сэжигтэй нөхцөл байдлыг мэдээлэх шаардлага тавьж болно.

АХБ: 14.А. АХБ-ны ажилтанууд шударга байдлын зөрчлийн аливаа сэжиг бүхий нөхцөл байдлыг АТШБА-нд мэдээлэх үүрэгтэй. Ажилтанууд мөн ЗЖ-ын 2.10.-ын дагуу албан тушаалын гэмт хэргийн сэжиг бүхий зөрчлийг ТБХМСГ-т мэдээлж болдог. Ажилтан шударга байдлын зөрчил болон албан тушаалын гэмт хэргийн нөхцөл байдлыг мэдээлэхэд ямар нэгэн баталгаа болон зөвшөөрөл шаардлагагүй.

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

15. Байгууллагын зүгээс ажилтануудаа эрэн сурвалжлах хяналт шалгалтын ажилд хамтран ажиллаж, асуултанд хариулах болон хүссэн мэдээллийг гаргаж өгөх шаардлага тавина.

АХБ: 15.А. АТШБА-наас шаардсан нөхцөлд АХБ-ны ажилтанууд¹³ урьдчилсан болон эрэн сурвалжлах хяналт шалгалтанд хамтран ажиллах үүрэгтэй. Энэхүү хамтран ажиллах байдал нь доорхи ба тэдгээрээр хязгаарлагдахгүй нөхцлийг шаардана:

- Асуулга ярилцлаганд биеэр оролцож асуусан бүх асуултад бүрэн бөгөөд үнэн зөв хариулт өгөх.
- АТШБА-ны хүсэлтийн дагуу тухайн ажилтан нь өөрийн шууд хяналтанд байгаа баримт бичиг болон бусад биет зүйлсийг гаргаж өгөх.
- АТШБА-наас шаардсан аливаа сорил туршилтыг өгөх; үүнд гарын хээний тодруулга өгөх, гар бичгийн задлан шинжилгээ өгөх, биет үзлэгт орох, психоанализ өгөх гэх мэт орно.
- АТШБА ба ТБХМСГ-тай хэлэлцсэн бүх мэдээллийг хадгалах ба нууцыг чандлан сахих.

үргэлжлэл дараагийн нүүрэнд

¹³ Үүнд Субъект болон гэрчүүд мөн багтана

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ...*үргэлжлэл*

15.В. Эрэн сурвалжлах хяналт шалгалтанд хамрагдаж буй ажилтан нь АТШБА-наас шаардсан тохиолдолд өөрийн санхүүгийн мэдээллийг шууд гаргаж өгөх ёстой. АТШБА-ны шаардлагын дагуу ажилтан нь өөрийн санхүүгийн байгууллагад үүссэн нөхцөл байдлын талаар бичгээр мэдэгдэл хүргүүлж өөрийн хамаарч байсан мэдээллийн чанд байдал болон нууцлалыг хариуцах эрхээсээ татгалзана.

15.С. Хяналт шалгалтанд хамрагдаж буй ажилтан нь хяналт шалгалтын хүрээнд хийгдэх ярилцлаганд өөр нэг ажилтантай цуг орох хүсэлтийг гаргаж болох ба тухайн хүсэлт нь хяналт шалгалтын ажлыг сунжруулах болон саад болохгүй нөхцөлд энэ хүсэлтийг хүлээж авна. Гэхдээ тухайн ярилцлаганд хамтран орох ажилтан нь АТШБА, ХЕЗА, Нарийн бичгийн дарга нарын газар, Ерөнхий Аудиторын газар, Захиргаа үйлчилгээний алба болон ТБХМСГ зэрэг нэгжид ажилладаг байж болохгүй. Ажилтан болон гэрч аль аль нь өөрсдийн зардлаар тухайн хяналт шалгалттай холбогдуулан гадны хуулийн байгууллагаас зөвөлгөө авч болох хэдий ч тухайн хуулийн

үргэлжлэл дараагийн нүүрэнд

¹⁴ Гэрч болох АХБ-ны ажилтнуудын хувьд сонголтоор

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

үргэлжлэл

зөвлөхийг АХБ-ны ажлын байр болон хяналт шалгалтын явцад хийгдэх ярилцлаганд дагуулан ирэхийг зөвшөөрөхгүй. Иймэрхүү зөвөлгөө нь АТШБА-наас зөвшөөрснөөс бусад тохиолдолд ярилцлага явуулах хугацааг хойшлуулах болон эдгээр журмын хүрээнд ажилтан бусад ямарваа нэгэн үүргийг ханган биелүүлэх хугацааг сунгах үндэслэл болохгүй.

15.D. Хэрвээ ажилтан хяналт шалгалтын ажилд хамтран ажиллах үүргээ биелүүлээгүй нөхцөлд АХБ-ны зүгээс үүнийг сөрөг гаргалгаа болгон ойлгоно. Энэ тохиолдолд ЗЖ-ын 2.04-ын дагуу АТШБА тухайн асуудлыг холбогдох сахилгын арга хэмжээ авахуулахаар ТБХМСГ-т хандаж болно. Хамтран ажиллах шаардлагыг биелүүлээгүй гэдэгт АТШБА-ны шаардлагад цаг тухайд нь болон бүрэн байдлаар хариу ирүүлэхгүй байх, АТШБА-ны хүссэн баримт бичиг болон нотолгоо гаргаж өгч чадаагүй, нотолгоо болох материалыг устгах болон нуун дарагдуулах, эсвэл худал мэдүүлэх эсвэл АТШБА-ны хяналт шалгалтанд саад учруулахыг ойлгоно.

¹⁵ Дагалдан оролцох ажилтны нэрийг АТШБА-д урьдчилан мэдэгдэнэ. АТШБА нь оролцуулахаас татгалзах, өөр этгээдээр солих хүсэлт гаргах эрхтэй.

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ...

16. Байгууллага бүр гуравдагч талтай байгуулж буй гэрээндээ эрэн сурвалжлах хяналт шалгалтанд хамрагдаж буй талууд хяналт шалгалтын ажилд дэмжлэг үзүүлж хамтран ажиллах тухай заалтыг хууль эрх зүйн болон арилжааны нөхцлүүддээ холбогдох дүрэм журам, бодлого, үйл ажиллагааны хүрээнд оруулж өгөх ёстой.

17. Эрэн сурвалжлах хяналт шалгалтын хүрээнд хяналт шалгалтанд хамрагдаж буй талд өөрийн байр суурь болон тухайн цаг үед өөрт нь тодорхой байгаа мэдээллийг тайлбарлах боломжийг олгох ёстой. Энэхүү боломжийг хяналтанд хамрагдаж буй талд хэдийд олгохыг Байгууллагын дүрэм журам, бодлого болон үйл ажиллагааны хүрээнд зохицуулна.

Эрэн сурвалжлах алба

18. Хяналт шалгалтыг тухайн үед олдох мэдээллийн эх сурвалжын хүрээнд шуурхай явуулах.

19. Эрэн сурвалжлах алба нь буруутгах болон цагаатгах мэдээллийг аль алиныг нь нягтална.

20. Эрэн сурвалжлах алба нь гүйцэтгэсэн хяналт шалгалт болон цуглуулсан мэдээллийн нэгдсэн бүртгэлийг найдвартай газар хадгалах ажлыг хариуцна.

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

АХБ: 20.А. АТШБА-нд хадгалагдана

- АХБ-ны ажилтантай холбоотой эрэн сурвалжлах ажиллагааны материалыг тухайн ажилтан АХБ-наас халагдсанаас хойш наад зах нь 10 жилийн хугацаанд хадгалах эсвэл тухайн ажилтаныг 70 нас хүртэл хадгалах эсвэл халагдсанаас хойш тухайн ажилтанг эргэн ажилд авахгүй байх зарчим барьдаг;
- Бусад эрэн сурвалжлах ажиллагааны материалыг тухайн хэрэгтэй холбоотой гомдлыг хүлээн авсанаас хойш наад зах нь 10 жилийн хугацаанд хадгална;
- Төслийн худалдан авалттай холбоотойгоор хяналт хийгдсэн материалыг тайлан гарсанаас хойш 5 жилийн хугацаанд хадгална;
- Аудит болон эрэн сурвалжлах ажиллагаа гүйцэтгэсэн Зөвлөхтэй байгуулсан гэрээг тухайн гэрээ хэрэгжиж дууссанаас хойш наад зах нь 5 жилийн хугацаанд хадгална;

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ...

үргэлжлэл

- Албан харилцааны материалууд; үүнд алба хоорондын уулзалтын тэмдэглэлүүд болон Удирдлагад хүргүүлсэн зөвлөмж материалыг наад зах нь 5 жилийн хугацаанд хадгална;
- АТШБА-ны Ерөнхийлөгчид хүргүүлсэн жилийн тайланг хугацаагүйгээр хадгална.

21. Эрэн сурвалжлах албаны ажилтанууд хяналт шалгалттай холбоотой мэдээллийг зөвшөөрөлгүйгээр гадагш алдахаас урьдчилан сэргийлэх шаардлагатай арга хэмжээг авах ёстой.

22. Эрэн сурвалжлах алба нь хяналт шалгалтаар цуглуулсан мэдээлэл болон дүгнэлтүүдийг баримтжуулах ёстой.

23. Хяналт шалгалтын ажиллагааг явуулах зорилгоор Эрэн сурвалжлах алба нь тухайн байгууллагын дүрэм, бодлого, үйл ажиллагааны журмын дагуу тухайн байгууллагын бүртгэл, боловсон хүчин болон өмч хөрөнгөтэй холбоотой бүх мэдээллийг үзэж танилцах бүрэн эрхтэй байна.

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

АХБ: 23.А. ЗЖ-ын АТШБА болон АТШБА-ны ажлын удирдамжтай холбоотой 1.02¹⁶-р заалтаар АХБ-ны бүх үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл болон бүртгэлийг саадгүйгээр нэвтрэн үзэх эрхийг олгодог. АТШБА нь АХБ-ны үйл ажиллагаатай холбоотой дурын болон бүхий л архивласан материал, тоон өгөгдөл, тайлангууд болон бусад холбогдох материалыг хянан үзэх, шаардлагатай тохиолдолд тухайн материалыг түр хугацаагаар хяналтын хугацаанд эзэмших болон хувилан ашиглах эрхтэй.¹⁶

23.В. АТШБА-ны цахим захидалыг нягталж танилцах хүсэлтийг ЗЖ-ын 4.05.¹⁷-р заалтын дагуу шийдвэрлэнэ.

24. Тухайн байгууллагын дүрэм журам, бодлого, үйл ажиллагааны хүрээ болон холбогдох гэрээгээр олгогдсон боломжийн дагуу Эрэн сурвалжлах алба нь тухайн байгууллагын санхүүжилттэй үйл ажиллагаанд оролцож байгаа болон оролцохоор төлөвлөж буй эсвэл тухайн байгууллагын гаргасан хөрөнгө санхүүг зарцуулахад оролцож буй хариуцагч агентлагууд, хувь хүмүүс, компаниуд болон хэрэгжиж буй төслүүдийн холбогдох данс бүртгэл тооцоог шалгах бүрэн эрхтэй байна.

¹⁶ *Information and Communication Technology Principles*, 11 September 2007.

¹⁷ *Мэдээлэл, Харилцаа Технологийн зарчмууд, 2007 оны 9-р сарын 11.*

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ...

25. Эрэн сурвалжлах алба нь бусад банкны байгууллагууд, олон улсын байгууллагууд ба холбогдох бусад талуудтай санал бодол, практик арга туршлага солилцох болон үүссэн асуудлыг харилцан хэрхэн хамгийн оновчтойгоор шийдвэрлэх арга замыг хэлэлцэн хамтран ажиллаж болно.

26. Эрэн сурвалжлах алба нь бусад эрэн сурвалжлах албадад дэмжлэг үзүүлэх болон мэдээлэл солилцож болно.

АХБ: 26.А. АТШБА болон Ерөнхийлөгч хяналт шалгалтын явцад олж цуглуулсан болон бусад мэдээллийг бусад олон улсын байгууллагууд, тэдгээрийн төлөөллүүд, АХБ-ны гишүүн орнуудын агентлагууд болон тухайн мэдээллийг хамтын ажиллагааны сонирхолын болон мэдээллийг ижилтгэх болон ЗЖ-ын 2,04 ба 2,10-р заалт, Олон нийттэй харилцах бодлого болон АХБ-ны бусад журамд заасан зориулалтаар ашиглуулах эсэхийг тогтооно. АТШБА-наас мэдээллийг ашиглуулах шийдвэр гарсан үед мэдээллийг хүлээн авагч талаас тухайн мэдээллийн нууцлалыг хангах болон мэдээллийг АТШБА-наас олгосон зориулалтын дагуу л ашиглах шаардлагыг тавина.

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

үргэлжлэл

26.В. АТШБА нь эрэн сурвалжлах ажиллагааны хүрээнд бусад байгууллага, албад болон талуудтай хамтран ажиллахдаа АТШБА-ны бие даасан байдал ба дүгнэлтийг үнэн зөвөөр гаргах явц ба АХБ-ны дүрмээр тогтоосон эрх мэдэл ба халдашгүй байдалд нөлөө үзүүлэхгүй байх зарчмыг баримтлан ажиллана.

АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

Гомдлын эх сурвалж

27. Эрэн сурвалжлах алба эх сурвалжаас нь үл хамааран бүх гомдлыг хүлээн авах ба үүнд нэргүй мэдээлэл болон нууц эх сурвалжтай гомдол хамаарна.

28. Боломжтой бол Эрэн сурвалжлах алба бүх гомдлыг хүлээж авсан талаараа хариу мэдэгдэж байх.

Гомдлыг хүлээн авах

29. Бүх гомдлуудыг бүртгэн авч хянан Эрэн сурвалжлах албаны хамаарах болон бүрэн эрхийн хүрээнд бүрэн нийцэж буй эсэхийг тогтооно.

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ...

Урьдчилсан үнэлгээ

30. Гомдлыг бүртгэж авсны дараа Эрэн сурвалжлах албанаас тухайн гомдлын үндэслэлийг, бодит байдлыг болон хяналт тавих боломжтой эсэхэд үнэлэлт өгнө. Энэ зорилгоор тухайн гомдлыг үндэслэл болгон эрэн сурвалжлах ажиллагаа явуулах эрх зүйн үндэслэл байгаа эсэхийг тодорхойлно.

АХБ: 30.А. АТШБА-наас хүлээн авсан гомдлуудыг цаашид эрэн сурвалжлах шаардлагатай эсэхийг доорхи шалгууруудаар шүүн үнэлэлт өгнө. Тухайн гомдлууд нь доорхи агуулга бүхий нотолгоо ба мэдээллийг агуулах ёстой

- АТШБА-ны мандатын хүрээнд байх – АТШБА-наас эрэн сурвалжилах бүрэн эрх нь олгогдсон үйл ажиллагааг л хамруулах;
- үнэмшил – зөрчил үнэхээр тохиолдсон байх тодорхой боломжууд байх;
- хяналт тавих боломж – тухайн зөрчлийн үнэн зөв байдлыг дэнслэхэд шаардлагатай хангалттай нотолгоог олж авах бодит хувилбар боломжууд байгаа эсэх;

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

үргэлжлэл

- баримтууд – байгаа мэдээлэл нь эрэн сурвалжлах ажиллагаа болон зөрчлийг арилгах арга хэмжээ авах тогтсон шаардлагад үндэслэл болохуйц чухал ач холбогдолтой байгаа эсэх
- холбогдох бусад шийдэл - өөрөөр хэлбэл асуудлыг АХБ-нд ашиглагдаж байгаа бусад арга хэлбэрээр шийдвэрлэх боломж бий эсэх.

30.В. Урьдчилсан хяналт шалгалтын дүгнэлтэнд АТШБА-ны ажилтан гомдлыг эцэслэн хаах эсвэл цаашид хяналт шалгалтыг үргэлжлүүлэх саналаа АТШБА-ны даргад эсвэл өөрийн ахлах түвшний удирдлагад хүргүүлнэ. Гомдлыг хаах болон хяналт шалгалтыг цаашид үргэлжүүлэх шийдвэрийг тусгайлан бэлтгэсэн тайланд баримтжуулах ба үүнд тухайн шийдвэрт хүрэх болсон шалтгааныг мөн тайлбарлана. Гомдолтой холбоотой мэдээллийг АТШБА-ны баримт бичигт энэ аргачлалын 20.А-р заалтанд заасан хугацаагаар хадгална.

30.С. Хэрэв гомдолд АХБ-ны ажилтан оролцсон бол холбогдох Захиргааны захирамжийн хүрээнд албан тушаалын гэмт хэрэг үйлдэгдсэн байж

үргэлжлэл дараагийн нүүрэнд

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ...

үргэлжлэл

болзошгүй байдлыг тооцон ТБХМСГ-тай хамтран дараагийн шатлалын хяналт шалгалтыг хийж болно. АТШБА энэ шалгалтыг хийх эсэхийг өөрийн сонголтоор шийдэх ба хяналтыг хийх нөхцөлд АТШБА-ны бие даасан байдал болон үнэн зөв дүгнэлт гаргах явцад нөлөөл үзүүлэх ёсгүй.

Хэргийн дарааллыг тогтоох

31. Эрэн сурвалжлах ажиллагаанд ямар хяналт шалгалтыг хамруулах шийдвэрийг тухайн байгууллагын дүрэм журам, бодлого ба үйл ажиллагааны хүрээнд шийднэ; Тухайлсан зөрчлийн үйлдэл болгонд зориулсан Эрэн сурвалжлах ажиллагааг ямар арга замаар явуулах шийдвэрийг Эрэн сурвалжлах алба хариуцан шийднэ.

32. Эрэн сурвалжлах үйл ажиллагааг төлөвлөх ба явуулах, хөрөнгө эх үүсвэрийг төсөвлөхдөө тухайн зөрчлийн ноцтой байдлын түвшин болон дагалдах үр дагаврыг тооцон үзэх ёстой.

Эрэн сурвалжлах ажиллагаа

33. Эрэн сурвалжлах алба нь бололцоотой тохиолдол бүрт тухайн мэдээллийн эх сурвалж дээр нэмэлт нотолгоог эрэлхийлэх ёстой.

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

34. Эдгээр аргачлалын зориулалтаар Эрэн сурвалжлах ажиллагааны хүрээнд баримт дээр суурилсан, видео, аудио, зурган болон цахим мэдээлэл эсвэл бусад материалыг цуглуулах, гэрчээс ярилцлагаар мэдүүлэг авах, хяналт хийж буй хүмүүст ажиглалт явуулах болон тухайн хяналт шалгалтын ажиллагааг явуулахад шаардлагатай эрэн сурвалжлах бусад арга техникийг ашиглана.

АХБ: 34.А. АТШБА –нь өөрийн сонголт шийдвэрээр хянан шалгах ажилд хамрагдаж буй талд урьдчилан мэдэгдэхгүйгээр баримт бичгэн, видео, фото зурган, компьютерээр болон дуу хураагуураар бичлэг хийх ажиллагааг АХБ-ны зохих журамд нийцсэн байдлаар явуулж нотолгоо баримт цуглуулж болно.

35. Эрэн сурвалжлах ажиллагааны явц болон голлох шийдвэрүүдийг бичгээр баримтжуулж Эрэн сурвалжлах албаны менежерүүд нягталж байх.

36. Тухайн байгууллагын дүрэм журам, бодлого болон үйл ажиллагааны хүрээнд Хяналт шалгалтын ажлын явцын аль ч хэсэгт Эрэн сурвалжлах албанаас тухайн хэрэгт анхаарал болгоомжтой хандаж урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд тухайн зөрчилд

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ...

сэжиглэгдэж буй ажилтанг хариуцаж байсан бичиг хэрэгт нэвтрэх болон ажлын байранд оруулахгүйгээр түр түтгэлзүүлэх, эсвэл үүрэгт ажлаас нь цалин болон урамшуулал авах нөхцөлтэй болон нөхцөлгүй байдлаар чөлөөлөх, эсвэл түүний албан үүргийн хүрээнд тодорхой хязгаарлалт тавих зайлшгүй нөхцөлд Эрэн сурвалжлах алба өөрийн байгууллагын доторхи эрх бүхий талуудад асуудлыг тавьж зохих арга хэмжээг авна.

37. Бололцоотой нөхцөлд Эрэн сурвалжлах албанаас явуулж буй асуулга ярилцлагыг 2 хүн байлцаж явуулна.

38. Эрэн сурвалжлах албаны сонголтоор асуулга ярилцлагыг тухайн ярилцлагыг өгч буй хүний төрөлх хэлээр явуулж болох ба боломжтой бол хэлмэрчээр дамжуулан ярилцлагыг хийнэ.

39. Эрэн сурвалжлах албанаас гэрч болон сэжигтэнээс мэдүүлэг авсны хариуд төлбөр төлөхгүй. Тухайн байгууллагын дүрэм журам, бодлого болон үйл ажиллагааны хүрээнд гэрч болон мэдээллийн өөр эх сурвалжууд Эрэн сурвалжлах албанд ирж уулзахад гарсан зохих зардлыг хариуцан төлөх асуудлыг тооцон үзэж болох юм.

40. Эрэн сурвалжлах алба өөрийн ажиллагаанд дэмжлэг болгож гадны байгууллагыг татан оролцуулж болно.

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ**ХЯНАЛТ ШАЛГАЛТААР ЦУГЛУУЛСАН
МЭДЭЭЛЭЛ**

41. Хэрэв Эрэн сурвалжлах албанаас тухайн гомдлын үндэслэлд хангалттай баримт мэдээлэл олж чадаагүй тохиолдолд тухайн нөхцөл байдлыг баримтжуулж, эрэн сурвалжлах ажлыг хааж энэ тухай холбогдох талуудад зохих ёсны дагуу мэдэгдэнэ.

АХБ: 41.А. АТШБА-ны тэргүүн ба АТШБА-ны дарга хамтран эрэн сурвалжлах ажиллагааг зогсоох зөвшөөрлийг өгнө. Зарим тохиолдолд тодорхой заагдсан хугацаанд дээрх 2 зөвшөөрлийг олж авах боломжгүй үед АТШБА-ны тохоон томилогдсон ахлах ажилтан Тэргүүн болон Даргыг орлож шийдвэрийг гаргах бүрэн эрхийг хэрэгжүүлж болно

42. Хэрэв Эрэн сурвалжлах алба гомдлын үндэслэлийг нотлох хангалттай хэмжээний мэдээлэл олсон тохиолдолд хяналт шалгалтаар цуглуулсан мэдээллийг баримтжуулж тухайн байгууллагын дүрэм журам, бодлого, үйл ажиллагааны дагуу асуудлыг байгууллагынхаа холбогдох хариуцлаганд хүргүүлнэ.

43. Эрэн сурвалжлах албаны хяналт шалгалтын үр дүнд тухайн гомдол нь үндэслэлгүй, санаатай худал гомдол

ОЛОН УЛСЫН САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН ЭРЭН СУРВАЛЖЛАХ...

байсан нь тогтоогдвол асуудлыг зохих журмын дагуу байгууллагынхаа холбогдох хариуцлагтанд хүргүүлнэ.

44. Эрэн сурвалжлах албаны хяналт шалгалтын үр дүнд гэрч болон сэжигтэй талын зүгээс хяналт шалгалтын дагуу хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн болох нь тогтоогдвол Эрэн сурвалжлах алба нь асуудлыг зохих журмын дагуу байгууллагынхаа холбогдох хариуцлагтанд хүргүүлнэ.

ТУХАЙН УЛСЫН АЛБАДАД ЛАВЛАГАА ӨГӨХ

45. Гомдолтой холбогдолтой мэдээллийн талаар лавлагааг тухайн улсын эрх мэдэл бүхий байгууллагуудтай хуваалцах эсэхийг Эрэн сурвалжлах алба шийдэх ба лавалгааг зайлшгүй өгөх нөхцөлд өөрийн байгууллагын хариуцлагатай талуудаас урьдчилан зөвшөөрөл авна.

ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БА НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ

46. Энэхүү удирдамжинд оруулах нэмэлт өөрчлөлтийг оролцогч байгууллагуудын нэгдсэн зөвшилцлөөр оруулдаг.

ХЭВЛЭН НИЙТЛЭХ

47. Ямар ч байгууллага мэдээллийг олон нийтэд хүргэх дотоод бодлогынхоо хүрээнд эдгээр Зарчмууд ба Удирдамжыг хэвлэн нийтэлж болно.

II. ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ

ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ҮНДЭСЛЭЛ

48. Шударга байдлыг зөрчсөн аливаа үйлдэл нь АХБ-ны зүгээс хориг арга хэмжээ авах зэрэг зөрчлийг арилгах ямар нэгэн арга хэмжээ авах үндэслэл болно. Үүнд АХБ-ны үйл ажиллагаанд холбоогүй зөрчлүүд ч багтаж болох юм.

49. Олон улсын хэмжээнд хар дансанд оруулах Хэлэлцээрийн дагуу,¹⁸ бусад оролцогч аль нэг байгууллагын зүгээс хар дансанд оруулсан талыг АХБ мөн хар дансанд оруулж болох АХБ-ны зүгээс хар дансанд оруулсан талыг бусад оролцогч байгууллагууд хар дансанд оруулж болно. АТШБА нь АХБ-ны зүгээс шийдвэрлэсэн Олон улсын хэмжээнд хар дансанд оруулах Хэлэлцээрт нийцсэн хар дансанд оруулах шийдвэр бүрийг болон тэдгээрт орсон өөрчлөлтийг бусад Оролцогч байгууллагуудад мэдэгдэж байх үүрэг хүлээдэг.

¹⁸ 2010 оны 4-р сарын 9-нд гарын үсэг зурагдсан ба удаа дараа нэмэлт өөрчлөлт орсон.

ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ

50. АХБ олон улсын бусад санхүүгийн байгууллагууд, хууль эрх зүйн болон зохицуулах үүрэг бүхий байгууллагуудын ёс зүйн зохих стандартыг баримтлаагүй тохиолдлуудад ашигладаг аливаа дүрэм, журам, үүргийн баримт бичигт үүнд тухайн улсын хууль болон зохицуулалтанд ёс зүйн стандартыг зөрчсөн агуулгыг АХБ-ны Авилгын эсрэг Бодлогод авч ашиглах шийдвэрийг гаргаж болно. Тухайн этгээд нь энэхүү Шударга байдлын зарчмууд ба Аргачлал баримт бичгийн дагуу зөрчлийг арилгах ямар нэгэн арга хэмжээ авагдаж болно.

51. Аливаа тал зөрчил арилгах арга хэмжээ авахуулах үндэслэл болсон аливаа үйлдэл болон үйлдэл хийх гэсэн оролдлого бүртээ, үүнд тухайн талын нэрийн өмнөөс ажилчид нь, агентууд нь болон төлөөлөл нь тухайн талын бүрэн эрхийг эдэлж байх явцдаа хийсэн аливаа үйлдэлдээ албан ёсны зөвшөөрөл авсан эс авснаас хамаарахгүй хариуцлага хүлээх болно¹⁹.

52. АХБ нь авилга болон залилангийн гэмт хэрэгт оноодог хууль болон шүүхийн тогтолцооны өргөн хүрээт бус харин энгийн бөгөөд, шударга, логик дэс

¹⁹ Дараах шаардлага хангагдсанаар 51-р заалт хүчинтэй байна: 1\ шударга байдлын зөрчлийг ажилтан\гүйцэтгэгч үйлдсэн болох нь тогтоогдсон, 2\ ажил олгогч-ажилтан, захиалагч-гүйцэтгэгч харилцаа үүссэн. Үүнийг хэрэгжүүлэхдээ, АШТБА нь бусад хучин зүйлс, үүн дотор тухайн компанийн дотоод хяналт, сахүүгийн удирдлагын зохистой байдал, шударга байдлын зөрчлийн талаарх удирдагуудын мэдлэг, оролцоо, компанийн цар хүрээ, олсон орлого зэргийг харгалзаж болно.

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

дараалалтай арга хэмжээг авдаг. АХБ-ны процедур нь захиргааны шинж чанартай бөгөөд хууль-шүүхийн, хуулийн эсвэл шүүхийн хэлбэрийн алийг ч агуулдаггүй.

53. Компани²⁰ болон хувь хүмүүст хориг арга хэмжээ авах замаар тэднийг эрхэлж буй бизнесээс нь шахаж гаргах нь АХБ-ны зорилго биш хэдий ч энэхүү нөхцөл байдлын бий болгож болох эрсдэл нь зохих хориг арга хэмжээг тэдэнд оногдуулах АХБ-ны байр суурьт нөлөөлөхгүй болно.

ЭРЭН СУРВАЛЖЛАХ АЖИЛЛАГААНД ХАМРУУЛАХ²¹ ТАЛААР ТАЛУУДАД МЭДЭГДЭХ

АХБ-ны Ажилтан

54. Ажилтануудад эрэн сурвалжлах ажиллагаанд хамруулах болсон талаархи мэдэгдлийг ЗЖ-ын 2.04-р заалтын дагуу хүргүүлнэ.

²⁰ “Компани” гэдэг үгийг энд ерөнхий утгаар ашигласан бөгөөд үүнд хууль эрх зүйн хувьд бие даасан статустай бөгөөд хувь хүнээс ялгагдах компани, корпораци, институци бүтцийн байгууллага, байгууллагууд ба аж ахуйн нэгжүүд багтана.

²¹ Тал гэдэгт компани ба хувь хүн хамрагдана.

Бусад талууд

55. Хэрэв хяналт шалгалтын үр дүнгээр аливаа тал шударга байдлын зөрчил гаргасан нь нотлогдвол АТШБА-наас өөрийн хяналтаар цуглуулсан мэдээллийг тухайн талд хүргүүлэх бүхий л бололцоот алхамуудыг хийж тухайн талаас хариу ирүүлэх боломжыг олгоно. Талуудтай холбоо барихдаа АТШБА тухайн талуудын АХБ-нд гаргаж өгсөн холбоо барих мэдээллийн үнэн зөв байдалд тулгуурлана. Хэдийгээр АТШБА-наас тухайн талтай холбоо барих хангалттай чармайлтыг гаргасан хэдий ч холбоо барьж чадаагүй нөхцөл байдал нь АХБ-ны зүгээс тухайн талд хориг арга хэмжээ авах шийдвэрийг өөрчлөхгүй.

56. АТШБА-наас аливаа олж тогтоосон мэдээллийг аль нэг компанид хүргүүлэхдээ АХБ-наас зөрчлийг арилгах арга хэмжээг тухайн компани, түүний салбарууд болон ажил хэргийн холбоотой талуудыг хамруулан авах болно гэдгээ тухайн компанид мэдэгдэнэ. АТШБА-наас мөн олж тогтоосон мэдээлэл болон зөвлөмжийг тухайн компани, түүний салбарууд болон ажил хэргийн холбоотой талуудад шууд хүргүүлэх бөгөөд эдгээрт тохирсон зөрчлийг арилгах арга хэмжээ авагдаж болно.

57. Талуудын хувьд тэдэнд тулгаж буй аливаа хэрэг, нотолгоод хариу өгөх бололжоор хангагдана. АТШБА-наас зарим нэг нотолгоо эсвэл мэдээлэл нь мэдээлэгч болон гэрчийн амь нас, эрүүл мэнд болон аюулгүй

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

байдалд заналхийлсэн нөхцөл байдлыг бий болгох магадлалтай эсвэл тухайн мэдээлэл нь эмзэг эсвэл нууцлалын түвшинтэй гэж үзвэл мэдээлэхгүй байж болно.

58. Хяналт шалгалтаар цуглуулсан мэдээллийг хүлээн авсанаас хойш календарийн 30 хоногоос багагүй хугацаанд талуудад нөхцөл байдлын хариу болгож бичгэн тайлбарыг хэрэв байвал холбогдох нотолгооны хамт ирүүлэх боломжоор хангадаг. Хүсэлт гаргасан болон тодорхой арга хэмжээ авсан байдлыг харгалзан АТШБА-наас энэхүү хугацаа дуусах товыг сунгаж болно.

59. 81 ба 82-р заалтанд тайлбарласан зөрчлийг хамтран үйлдсэн бөгөөд ил тодорхой байгаа талуудад ч тусад нь мэдэгдэл хүргүүлэх бөгөөд хариу өгөх адил боломжийг олгоно.

60. Тухайн тал АТШБА-нд амаар тайлбар өгөх хүсэлтийг гаргаж болох бөгөөд үүний учир шалтгааны тайлбарыг мөн өгнө.

61. АТШБА тухайн талаас хариу тайлбар хүлээн авсаны дараа хэргийг дахин үнэлэлт өгч цаашид хяналт шалгалтыг үргэлжлүүлэх эсвэл тухайн талаас нэмэлт мэдээлэл хүсэх шийдвэрийг гаргана.

62. АТШБА-ны тогтоосноор аливаа тал АТШБА-ны зүгээс шударга байдлын зөрчилтэй холбогдуулан явуулсан

ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ

хяналт шалгалтын үр дүнг хүлээн зөвшөөрөхгүй маргаан үүсгэсэн эсвэл танилцуулсан хяналтын үр дүнд хариу өгөхгүй нөхцөлд АТШБА-наас өөрийн явуулсан эрэн сурвалжлах ажлын тайланг Шударга байдлын Хяналтын хороо (ШБХХ)-нд холбогдох тайлбарын хамтаар явуулна, хэрэв тухайн талаас хариу тайлбар ирүүлсэн бол түүнийг ч хавсаргана.

Хяналтын үр дүн ба авах арга хэмжээний талаар мэдэгдэх

63. АТШБА-наас хяналт шалгалтын үр дүнгийн талаархи албан бичгийг тухайн зөрчилд авагдах арга хэмжээний саналын хамтаар хүргүүлнэ. Тухайн захидалыг хүлээн авсан талд албан бичгийн огнооноос хойш 30-аас доошгүй календарийн хоногийн хангалттай хугацаа өгч албан бичигт хариу ирүүлэх болон санал болгож буй арга хэмжээг хүлээн зөвшөөрч байгаа эсэх тухай нь хариу авна.

64. Тухайн талын зүгээс ямар нэгэн маргаан үүсгэхгүйгээр шалгалтын үр дүн болон авахаар төлөвлөж буй арга хэмжээг хүлээн зөвшөөрсөн нөхцөлд албан бичигт заасан хугацааны дотор албан бичгийг хүлээн авсан болон авахаар төлөвлөж буй арга хэмжээг зөвшөөрч буйгаа албан бичигт заагдсан хугацааны дотор батлан хариу мэдэгдэнэ. Ингэж батлан хариу мэдэгдсэнээр тухайн тал авахаар төлөвлөж буй хориг арга хэмжээ болон түүний хугацааны талаар зарга

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

мэдүүлэхгүй хэмээн зөвшөөрч байна гэж ойлгогдоно. Баталсан хариу албан бичгийг хугацаанд АТШБА-нд ирүүлсэн нөхцөлд тухайн хориг арга хэмжээний үйлчлэх хугацаа албан ёсоор эхэлнэ.

65. Хэрэв тухайн тал цуглуулсан мэдээлэл болон санал болгосон хориг арга хэмжээний эсрэг маргаан үүсгэвэл 62-р заалтын дагуу асуудлыг ШБХХ-нд хүргүүлнэ.

Мэдэгдлийг хүлээн авахаас татгалзах\хүлээж аваад хариулахгүй байх

66. АШТБА-ны мэдэгдлийг аливаа тал хүлээн авахаас татгалзсан, эсвэл мэдэгдлийг хүлээн авсан ч хариу ирүүлэхгүй байх нөхцөлд тус албанаас буруутай гэх дүгнэлт гаргах бөгөөд хэргийг хүндрүүлэх нөхцөл байдал үүсгэсэн гэж үзнэ. Ийнхүү татгалзсан талын эсрэг хориг арга хэмжээ авагдсан тохиолдолд ШБХХ болон АШТБА уг арга хэмжээ нь тухайн талын хувьд эхний удаагийн хориг арга хэмжээ байхаас үл хамааран нийтэд зарлах үндэслэлтэй гэж үзэх бөгөөд энэ нь олон улсад хар жагсаалтад орох шалтгаан болж болно.

ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ

Засгийн газар

67. Хэрэв хяналт шалгалтын явцад засгийн газрын эрх мэдэлтнүүд шударга байдлын зөрчилд оролцсон болох

ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ

нь тогтоогдвол АТШБА хяналтын үр дүнгийн тайланг Менежментэд/удирдлагадаа хүргүүлнэ. АТШБА өөрийн удирдлага болон үйл ажиллагааны газруудтай хамтран ажиллаж АХБ-ны Авилгын эсрэг Бодлого болон бусад дүрэм журам, бодлого, үйл ажиллагааны хүрээнд асуудлыг хэрхэн авч үзэж АХБ-ны зүгээс ямар арга хэмжээ авах боломж нөхцлийг үнэлэх болно.

АХБ-ны Ажилтан

68. Хэрэв хяналт шалгалтын явцад АХБ-ны ажилтан шударга байдлын зөрчил болон албан тушаалын бусад гэмт хэрэгт оролцсон болох нь тогтоогдвол АТШБА-наас Захиргааны журам (ЗЖ)-ын 2.04-ын дагуу холбогдох сахилгын арга хэмжээ авахуулах дүгнэлтийг ТБХМСГ-т хүргүүлнэ. АТШБА хяналтын үр дүнгийн тайланг ТБХМСГ-т хүргүүлнэ. ЗЖ-ын 2.04-р заалтын дагуу сахилгын арга хэмжээ авах асуудлыг ТБХМСГ дангаараа хариуцдаг хэдий ч сахилгын аливаа арга хэмжээ оногдуулах шийдвэр гаргах явцад АТШБА нь ТБХМСГ-тай асуудлыг хэлэлцэж, дэмжлэг үзүүлэн ажиллаж болно.

Шударга байдлын хяналтын Хороо (ШБХХ)

69. ШБХХ нь санал өгөх эрхтэй 3 гишүүнээс бүрдэх ба тэдгээрийн 1 нь нэр хүндтэй бөгөөд АХБ-ны ажилтан биш хөндлөнгийн төлөөлөл байна. АТШБА-ны дарга гишүүдэд нэр дэвшигчдийг санал болгох ба Ерөнхийлөгч АХБ-ны ахмад ажилчдын дундаас гишүүдийг тогтоосон

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

хугацаагаар томилж ажиллуулна.²² Ерөнхийлөгчийн шийдвэрээр АТШБА-ны дарга эсвэл түүнтэй ойролцоо тушаалын ажилтанг ШБХХ-ны санал өгөх эрхгүй гишүүнээр ажиллаж ШБХХ-ны зарлан хуралдуулах хурлуудад оролцох гишүүд нь түүний шийдвэрийг хэлэлцэхдээ ашиг сонирхолын зөрчилгүй байх асуудлыг нягтлах үүрэгтэй байна. Шалгагдаж буй асуудалд хамаарах мэдлэг туршлагатай бусад газар хэлтсийн ажилтанууд болон төлөөлөл ШБХХ-ны хуралд дуудагдан тодорхой зөвөлгөө өгч болно. ШБХХ-ны шийдвэр нь олонхийн зарчмаар гардаг хэдий ч үүнд ШБХХ-ны хөндлөнгийн гишүүний санал орсон байна. Хөндлөнгийн гишүүний санал олонхийн шийдвэрт ороогүй тохиолдолд нарийн бичгийн дарга нарын газраас шинэ уулзалтыг зарлах ба үүнд хэргийг анхлан хэлэлцсэн 3 гишүүн, үүний дээр байгууллагын зүгээс 1 нэмэлт гишүүн ба хөндлөнгийн 1 гишүүнийг оролцуулна. ШБХХ-ны зарлан хуралдуулсан 2 дах уулзалтаар шийдвэр олонхийн саналаар гарах ёстой.

70. Ашиг сонирхолын зөрчлийн тухай мэдээллийг нарийн бичгийн дарга нарын газраар дамжуулан ШБХХ-нд гаргана. ШБХХ-ны гишүүн эсвэл зөвлөх өөрийнх нь хувьд ашиг сонирхолын зөрчилтэй аливаа асуудлыг хэлэлцэх болон шийдвэрлэх хурлуудад оролцохоос татгалзана. Ашиг сонирхолын зөрчил байгаа үгүй талаар маргаан үүссэн нөхцөлд асуудлыг ШБХХ-ны

²² Хугацаа нь ердийн нөхцөлд 24 сар байдаг ба АТШБА-ны дарга болон Ерөнхийлөгч өөр хугацааг оногдуулж болох юм.

ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ

бусад гишүүд шийдвэрлэнэ. Хурлаас татгалзаж байгаа байдал ба ашиг сонирхолын зөрчлийн талаар гарсан шийдвэрийг нарийн бичгийн даргын газар бичгээр баримтжуулна.

71. ШБХХ нь АТШБА-ны зүгээс тухайн тал АХБ-ны Авилгатай тэмцэх бодлогыг зөрчсөн болохыг нотлож хүргүүлсэн тайлан болон бусад мэдээлэл нь зөрчлийг арилгах хориг арга хэмжээ оногдуулах бүрэн үндэслэл болж чадах эсэхийг тогтоодог. ШБХХ нь авч хэлэлцсэн зөрчлийн тохиолдлуудтай холбоотой үйл ажиллагааны зөвлөмжийг гаргаж өгч болох ба мөн онцгой нөхцлүүдэд 110 ба 113-р заалтын дагуу хориг арга хэмжээ авагдсан компани болон хувь хүний нэрийг олон нийтэд зарлах эсэхийг авч хэлэлцэнэ.

Түр түтгэлзүүлэх

72. Эрэн сурвалжлах ажиллагааны аль ч үе шатанд АТШБА-наас тухайн талын шударга байдлын зөрчил гаргасаныг нотлох хангалттай нотолгоо олдсон болон хяналт шалгалтыг бүрэн хэмжээгээр явуулахад дээд тал нь 1 жил орчим хугацаа орох тохиолдолд АТШБА-наас ШБХХ-нд татгалзах нөхцөлгүйгээр тухайн талын үйл ажиллагааг түр түтгэлзүүлэх хүсэлтийг хүргүүлнэ. Энэхүү хүсэлтэнд одоогоор явагдаж буй хяналт шалгалтын ажлын явц, цаашид нэмэлтээр цуглуулах нотолгоо баримт ба тэдгээрийг цуглуулж хяналт шалгалтыг дуусгахад шаардлагатай хугацааг дурьдсан байна.

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

73. Үүнтэй адилаар тухайн талын үйл ажиллагааг Оролцогч байгууллагын зүгээс түр түтгэлзүүлсэн нөхцөлд тухайн талыг аливаа үйл ажиллагаанд үргэлжлүүлэн оролцуулах нь нэр төрийн эрсдэл улмаар тухайн хориг арга хэмжээ авагдсан тал нь шударга байдлын зөрчил гаргах эрсдлийг тооцон үзэж Оролцогч талтай хэлэлцсэний үндсэн дээр тухайн тал шударга байдлын зөрчил гаргасан талаар хангалттай хэмжээний нотлох баримт цугласан болон хяналт шалгалтыг бүрэн дуусгахад дээд тал нь 1 жилийн хугацаа шаардагдах нөхцөлд АТШБА-наас ШБХХ-нд татгалзах нөхцөлгүйгээр тухайн талын үйл ажиллагааг түр түтгэлзүүлэх хүсэлтийг хүргүүлэх ба Оролцогч байгууллагын зүгээс тухайн талын үйл ажиллагааг түр түтгэлзүүлэх арга хэмжээ авсан нөхцөл байдлын товч тайлбарыг хавсарган хүргүүлнэ.

74. Түр түтгэлзүүлэх арга хэмжээг хэлэлцэхийн тулд ШБХХ нь 3 гишүүнээс бүрдэх ба гадны нэмэлт гишүүнийг байлгах шаардлагагүй.²³

75. Түр түтгэлзүүлэх арга хэмжээг 180 хүртэл хоногийн хугацаагаар оногдуулж болно. Энэхүү түр түтгэлзүүлэх анхны хугацааг хэрэв нөхцөл байдал шаардвал АТШБА-ны зөвшөөрлөөр дахин нэмэлт 180 хоногийн хугацаагаар сунгаж болно. Түр түтгэлзүүлэх арга хэмжээг 360 хоногоос дээш хугацаагаар сунгахгүй.

²³ АШТБА нь ШБХХ-ны зөвлөмжийг холбогдох талуудад хүргүүлнэ.

ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ

76. Тухайн этгээдэд түр түтгэлзүүлэх арга хэмжээ авах болсон талаар мэдэгдэж АХБ-ны санхүүжилттэй, хариуцан хэрэгжүүлж буй эсвэл дэмжлэгтэй үйл ажиллагаанд оролцох боломжгүй болсон тухай зөвлөмжийг хүргүүлдэг. Түр түтгэлзүүлэх арга хэмжээний эсрэг зарга үүсгэхгүй.

77. Түр түтгэлзүүлэх арга хэмжээ авагдсан тал АХБ-ны санхүүжүүлж буй, хариуцан хэрэгжүүлж байгаа болон дэмжиж буй аливаа үйл ажиллагаанд оролцох эрхгүй болдог. Түр түтгэлзүүлэх арга хэмжээ авагдсан байх хугацаандаа АХБ-ны санхүүжүүлсэн, хариуцан явуулж буй болон дэмжлэгтэй үйл ажиллагаанд оролцох аливаа оролдлого нь автоматаар 3 жилийн хориг арга хэмжээ болж өөрчлөгдөх ба 88-р заалтын дагуу энэхүү хугацааг нэмэгдүүлж эсвэл хасаж болох ба АХБ-ны вэбсайтад мэдээлэгдэх болно. АХБ-ны вэбсайтад мэдээлэгдэх нь Олон улсын хар дансанд орох үр дагаварт хүргэж болно.

78. Түр түтгэлзүүлэх арга хэмжээ авагдсан талын эсрэг хориг арга хэмжээ авах тохиолдолд уг арга хэмжээний хүчинтэй хугацааг түр түдгэлдүүдэх хугацааг хамруулах байдлаар нөхөн тооцно.

Хориг арга хэмжээ

79. АТШБА ба ШБХХ-ноос тухайн талыг АХБ-ны санхүүжилттэй, хариуцан хэрэгжүүлж буй болон дэмжлэгтэй үйл ажиллагаанд оролцохыг хориглосон шийдвэрийг гаргаж болно:

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

i. **Эрхийг хасах:** Эрхийг хасна гэдэг нь ёс зүйн өндөр хэм хэмжээг баримтлаагүй тухайн талтай АХБ цаашид хамтран ажил хэрэг явуулахгүй гэсэн захиргааны шийдвэрийг илэрхийлдэг. Эрхийг хасах нь одоогоор хэрэгжүүлж буй гэрээний үүрэгт нөлөөлөхгүй байж болох бөгөөд ШБХХ ба АТШБА тухайн гэрээний үүрэгт өөрчлөлт оруулах саналыг хүргүүлж болно.²⁴

Тодорхойгүй хугацаагаар эрхийг хасахаас бусад эрхийг хасах тохиолдлууд тогтоосон наад захын хугацаатай байна.

ii. **Эргэн сэргээх нөхцөлтэйгээр эрхийг хасах:** ШБХХ ба АТШБА нь тухайн талын эрхийг хасах хориг арга хэмжээг авахдаа тодорхой нөхцлийг тавьж хэрэв тэдгээрийг биелүүлвэл хориг арга хэмжээний хугацааг багасгах шийдвэр гаргаж болно. Тавигдах нөхцлүүдэд: (a) шударга байдал ба компанийн хяналтыг сайжруулах эсвэл хуулийн нийцлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх; (b) шударга байдлын зөрчил гаргасан этгээдэд сахилгын/ажлаас халах арга хэмжээ авах; (c) зөрчлөөр учруулсан хохиролыг нөхөн төлбөр болон бусад залруулах арга хэмжээгээр барагдуулах.

Нөхцөлтэйгээр эрхийг сэргээлгэх арга хэмжээ авагдсан тал тухайн нөхцлүүдийг хангасан гэж үзсэн

²⁴ Шаардлагатай нөхцөлд ШБХХ-той цахим уулзалтыг мөн зарлан хуралдуулж болно.

ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ

үедээ эрхээ сэргээлгэх хүсэлтийг тавьж болно. ТШБА-наас тухайн нөхцлүүдийг хангасан эсэхийг нягтлах ба хяналтын үр дүнд эрхийг хасах арга хэмжээг цуцлах эсэхийг тогтооно.

iii. **Эрхийг хасахгүйгээр тусгай нөхцөл тавих:** АТШБА ба ШБХХ-ноос тухайн тал тодорхой алхамуудыг хийсэн гэж үзсэн нөхцөлд эрхийг хасахгүй байж болно. Энэ тохиолдолд хориг арга хэмжээ авагдаж буй талын эрхийг хасахгүй ба харин тодорхой хугацаат нөхцлүүдийг АТШБА ба ШБХХ-ноос тавьдаг. Эрхийг хасахгүйгээр тусгай нөхцөл тавих арга хэмжээ авагдсаны дараа тухайн тал заагдсан хугацаанд тухайн нөхцлүүдийг хангаагүй нөхцөлд АТШБА ба ШБХХ-ноос тогтоосон хугацаагаар тухайн талын эрх автоматаар хасагдана.

80. Төөрөгдүүлэлт үүсэхээс урьдчилан сэргийлж хориг арга хэмжээг тухайн талын ирээдүйн эрх ашиг болон хяналтанд орж болох одоогоор тухайн талыг хянаж байдаг болон тухайн талын хяналтанд байдаг бүхий л байгууллагуудад хамааруулдаг.

81. Хэрэв зөрчлийг хамтарсан талууд; үүнд хамтарсан компани орно. Энэ нөхцөлд АТШБА ба ШБХХ-ноос оногдуулах хориг арга хэмжээг шударга байдлын зөрчлийг үйлдсэн талд нь л оногдуулна.

82. Тухайн компанийн шууд хамтарсан талууд (эзэд, дарга нар, ажилтанууд ба голлох хувьцаа эзэмшигчид)

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

болон ажил хэргийн холбоотой талуудад хэдийгээр шударга байдлын зөрчлийг тэд шууд үйлдээгүй ч гэсэн АТШБА ба ШБХХ-ноос оногдуулах хориг арга хэмжээг хамааруулдаг. Хэн болох нь тодорхой тохиолдолд хамсаатнуудыг хориг арга хэмжээнд нэр заан оруулах ба доорхи хамаарал бүхий этгээдүүдэд энэ заалт үйлчилж болно:

- i. гэр бүлийн холбоотой;
- ii. тухайн этгээдийг шууд болон шууд бус замаар хянах болон ихээхэн нөлөөлөх боломжтой талууд;
- iii. тодорхой хувь заасан эзэмшил болон эзэмших эрхэд хамаарахгүй ч эзэмшил, менежмент, хяналтын нэгдмэл болон холбоотой сонирхол бүхий талууд
- iv. өөр талтай хэлэлцэн тохирсон болон хараат байдалд орсо талууд.

83. хамтран ажилладаг талууд, гол буруутан болон холбоотой талуудад оногдуулах хориг арга хэмжээг тогтоохдоо ШБХХ болон АТШБА-ны зүгээс мөн доорхи нөхцөл байдлыг харгалзан үзнэ:

- i. менежментийн болон байгууллагын бүтэц;
- ii. холбоотой тал нь шударга байдлын зөрчилд оролцсон эсэх эсвэл зөрчил гарахад нөлөөлсөн эсэх эсвэл тухайн зөрчлөөс бий болсон үр шимийг хүртэгч байсан эсэх;

ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ

iii. мөн тухайн тал өөрийн хамсаатанууд руу хяналт шалгалтыг төөрөгдүүлэн шилжүүлэх замаар хариуцлагаас зайлсхийх эсвэл бизнесийн гол ашигаа дамжуулан авдаг хамсаатанаа хяналт шалгалтаас тойруулан бултуулах зэрэг нөхцөл байдлыг бүрдүүлэх оролдлого.

84. Боломжтой бол ШБХХ болон АТШБА-ны зүгээс АТШБА-ны явуулсан эрэн сурвалжлах, хянан шалгах ажилд хамтран ажилласан талд хориг арга хэмжээ авах шийдвэр оногдуулахгүй байж болно.

85. Шударга байдлын зөрчлийг санаатайгаар болон санамсаргүй үйлдсэн/үйлдэж буй талуудад энэ тухайгаа АТШБА-д шуурхай мэдээлэх хөшүүргийг бий болгох үүднээс шударга байдлын зөрчлийн талаар сайн дурын үндсэн дээр мэдүүлж АХБ-тай бүрэн хамтран ажилласан талын эсрэг авах хориг арга хэмжээг хүчингүй болгох эсвэл хөнгөвчлөх саналыг дараах шаардлагууд хангагдсан нөхцөлд АТШБА-ны зүгээс гаргаж болно:

- i. Шударга байдлыг зөрчлийг тухайн тал гаргаахаа болисон,
- ii. Одоо болон урд өмнө үйлдсэн шударга байдлын зөрчлийн талаарх бүрэн бөгөөд үнэн зөв мэдээллийг байнга өгсөн, цаашдаа ч өгөх
- iii. Зөрчлийн талаарх мэдээлийг цаг тухайд нь буюу мэдмэгцээ хамгийн боломжит богино хугацаанд өгсөн

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

iv. Тухайн талтай холбогдох АХБ-ны болон олон улсын санхүүгийн, олон талт хөгжлийн болон хоёр талт аливаа байгууллагын эрэн сурвэлжлах хяналт шалгалт яг энэ цаг үед хэрэгжээгүй.

Асуудлыг шийдвэрлэх тогтсон арга замын дагуу, тухайн тал дараах нөхцөл байдалтай болохыг АХБ-ны зүгээс аль ч үед жич тодорхойлсон тохиолдолд хориг арга хэмжээ болон бусад арга хэмжээг авах эрхийг АХБ эдэлнэ:

- a. шударга байдлын зөрчлийг үргэлжлүүлэн үйлдсэн эсвэл бусад зөрчлийг үйлдсэн
- b. шударга байдлын зөрчлийн талаар мэдүүлэхдээ дутуу мэдээлсэн
- c. АШТБА-д 85-р заалтыг баримтлан мэдүүлээгүй
- d. Мэдүүлэг хийх үедээ АХБ-ны болон олон улсын санхүүгийн аль нэг өөр байгууллагын эрэн сурвэлжлах хяналт шалгалтад хамрагдсан байсан
- e. Хориг арга хэмжээг түдгэлзүүлэх, хөнгөлөх тухай АШТБА-ны нөхцлийг биелүүлээгүй.

Зөрчлийг арилгах бусад арга зам

86. АХБ-ны зүгээс АТШБА ба ШБХХ-ны тогтоосноор зөрчлийг арилгах зориулалтаар оногдуулж болох бусад арга хэмжээнд:

ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ

- i. **Сануулга:** Сануулга гэдэг нь зөрчлийг дахин гаргах нөхцөлд оногдуулах хариуцлага нь илүү өндөр байх болно шүү гэдгийг тухайн талд сануулж буй шийтгэл юм. Хяналт шалгалт тааруугаас зөрчил үүссэн болон тухайн талын шударга байдлын зөрчилд оруулсан хувь оролцоо харьцангуй бага нөхцөлд сануулгыг бичгэн хэлбэрээр хүргүүлэх нь оновчтой.
- ii. **Нөхөн төлбөр төлөх:** Нөхөн төлбөр болон санхүүгийн бусад хэлбэрийн шийтгэлийг өөр төрлийн хориг арга хэмжээтэй хавсран болон дангаар нь оногдуулж болно.
- iii. **Анхааруулах:** Анхааруулгыг шударга байдлын зөрчилд тооцогдохооргүй бага зэргийн алдаа гаргасан талд оногдуулна. (ердийн хайнга байдал гэх мэт).

87. Сануулга авах, нөхөн төлбөр төлөх болон анхааруулах арга хэмжээ авагдах нь тухайн этгээдийн АХБ-ны санхүүжилттэй, хариуцан хэрэгжүүлж буй болон санхүүгийн дэмжлэгтэй үйл ажиллагаануудад оролцох эрхэд нөлөөлөхгүй.

АХБ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ ЭРХИЙГ ХАСАХ ХУГАЦАА

88. Шударга байдлын зөрчлийг үйлдсэн тохиолдлуудад эрхийг хасах хугацаа нь 3 жил байна. Тухайн хэрэг

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

бүрийн нөхцөл байдлаас хамааран үүнээс их болон бага хугацаагаар эрхийг хасахыг АТШБА ба ШБХХ шийднэ. Дунджаас их болон бага хугацаа оногдуулахдаа АТШБА ба ШБХХ доорхи хүчин зүйлүүдийг тооцож үзнэ:

- i. Олон нийтийн аюулгүй байдал, амьдрах орчинд, төсөлд улмаар АХБ-ны хууль ёсны эрх ашигт үзүүлсэн бодит болон болзошгүй хор хохирол;
- ii. шударга байдлын зөрчлийн нарийн төвөгтэй байдлын зэрэг, өөрөөр хэлбэл, төлөвлөсөн байдал, ашигласан техникийн төрөл, нуун дарагдуулсан түвшин, оролцсон байгууллага хувь хүний тоо ба төрөл, зөрчлийн үргэлжилсэн хугацаа, тухайн зөрчлийн газарзүйн тархалт гэх мэт;
- iii. удирдлага болон байгууллагын оролцоо ба хяналтын түвшин;
- iv. шударга байдлын зөрчлийг үйлдэхэд оролцсон оролцооны байдал; өөрөөр хэлбэл манлайлан оролцсон эсэх, илэрхий оролцсон эсэх эсвэл тун бага оролцсон эсэх
- v. АТШБА-наас хяналт шалгалтын ажлыг эхлүүлсэнийг мэдсэний дараа тухайн тал шударга байдлын зөрчлийг үргэлжлүүлэн үйлдсэн эсэх болон зөрчлийг өөрийн сайн дураар таслан зогсоосон эсэх;
- vi. эрэн сурвалжлах ажилд хамтран ажилласан болон саад учруулсан байдлын түвшин;

ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ

- vii. тухайн этгээд өмнө нь АХБ-ны зүгээс хориг арга хэмжээ авагдаж байсан эсвэл өөр бусад байгууллагын зүгээс хориг арга хэмжээ болон хар дансны жагсаалтанд орж байсан эсэх;
- viii. АХБ-ны зүгээс тухайн талын эсрэг аливаа арга хэмжээг өмнө авсан эсэх
- ix. тухайн талын компани захиралууд, ажилтанууд болон бусад салбарын талаархи дэлгэрэнгүй мэдээлэл;
- x. шударга байдлын зөрчилд төрийн албан хаагчдын болон АХБ-ны ажилтануудын оролцсон байдал болон гүйцэтгэсэн үүрэг;
- xi. үүссэн нөхцөл байдлыг шийдэхийн тулд анхны эрхийг сэргээсэн болон өөр алхам хийгдсэн эсэх;
- xii. шударга байдлын зөрчлийг дахин гаргахгүй байхын тулд дотоод хяналтаа бэхжүүлэх чиглэлд дотоод засаглалын механизмыг бүрдүүлсэн, сайжруулсан болон хэрэгжүүлсэн байдал;
- xiii. хэрэв олон улсын хөгжлийн өөр банк болон олон улсын байгууллага тухайн этгээдийн эрхийг хасаж байсан бол;

89. АХБ-ны үйл ажиллагаанд оролцох эрхийг хасах хугацааг тогтоохдоо АШТБА болон ШБХХ нь дараах байдлаар жишгийг баримтална:

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

- i. Эрх анх удаа хасагдаж байгаа, үүн дотор тухайн тал өмнө сануулга авч байсан тохиолдлуудад:
 - a. хувь хүмүүс - тодорхойгүй хугацаагаар
 - b. компани - 7 жил хүртэлх хугацаагаар
- ii. Эрх хоёрдахь удаад хасагдаж байгаа тохиолдолд:
 - a. хувь хүмүүс - тодорхойгүй хугацаагаар
 - b. компани - 10 жил хүртэлх хугацаагаар
- iii. Эрх хоёроос олон дахин хасагдаж байгаа тохиолдолд:
 - a. хувь хүмүүс - тодорхойгүй хугацаагаар
 - b. компани - 20 жил хүртэлх хугацаагаар

90. Аливаа компани эзэмшил, байгууллагын бүтэц зохион байгуулалт, удирдлага тодорхой хугацааны дараа өөрчлөгдөн солигддог нөхцөл байдлыг тооцон үзэж АХБ-ны зүгээс компани эрхийг тодорхой онцгой нөхцлүүдэд л (өөрөөр хэлбэл шударга байдлын зөрчлийг удаа дараа үйлдэх, АХБ-ны хууль ёсны эрх ашигт ихээхэн хэмжээний хохирол учруулах) тодорхойгүй хугацаагаар хасдаг. Хувь хүний зан төлөв бараг засардаггүй нөхцлийг тооцон үзэж АХБ-ны зүгээс шударга байдлын аливаа зөрчил үйлдсэн хувь хүний АХБ-ны үйл ажиллагаанд оролцох эрхийг тодорхойгүй хугацаагаар хасдаг.

ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ

91. Хэрэв тухайн тал шударга байдлын зөрчлийн хэд хэдэн үйлдлийг нэгж хугацаанд болон ойролцоо хугацаанд нэг эсвэл өөр өөр төслүүдэд (өөрөөр хэлбэл худалдан авалтын явцад үгсэн хуйвалдалт болон буруу мэдээлэл өгсөн) үйлдсэн бол тухайн талыг хуримтлагдсан байдлаар эсвэл үйлдэл тус бүрд нь хориг арга хэмжээ авна.

92. Хэрэв хориг араг хэмжээ авагдсан тал АХБ-ны санхүүжилттэй гэрээг одоо хэрэгжүүлж байгаа бол энэхүү нөхцөл байдал нь тухайн гэрээний үүрэгт нөлөөлөхгүй байж болно. Гэрээнд оруулах аливаа өөрчлөлт нь тухайн хориг арга хэмжээний үр нөлөөг сулруулах болон төөрөгдүүлэх оролдлого байж болох нөхцөл шалтгааны улмаас АТШБА-аар зайлшгүй хянагдаж батлагдах ёстой. Одоогоор хэрэгжүүлж буй гэрээнд оруулах өөрчлөлтийг АТШБА-наас татгалзахгүй нөхцлөөр хүлээн зөвшөөрүүлэх нь холбогдох нэгжийн болон хориг арга хэмжээ авагдсан талын үүрэг байх болно.²⁵ Хориг арга хэмжээ авагдсан талаас хянуулан батлуулах хүсэлтийг гаргаагүй нөхцөлд эрх хансагдах хугацаа сунгагдаж болно.

²⁵ Хориг арга хэмжээ авагдсан тал гэрээний өөрчлөлтийн хүсэлтийг АХБ-ны үйл ажиллагааны хэлтсүүд, хариуцагч болон хэрэгжүүлэгч агентлагт гаргаж эцэст нь АТШБА-аар батлуулна.

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

Хориг арга хэмжээг зөрчих

93. Хориг арга хэмжээ авагдсан байх хугацаандаа АХБ-ны санхүүжүүлсэн болон дэмжлэгтэй үйл ажиллагаанд оролцохыг завдах, оролцох болон АТШБА-наас батлаагүй байхад гэрээнд аливаа өөрчлөлт оруулах зэргийг хориг арга хэмжээг зөрчсөнд тооцно. Ийм тохиолдолуудад АХБ энэ баримт бичгийн 88 ба 89-р бүлгийн дагуу хориг арга хэмжээг сунгана. Хориг арга хэмжээг сунгах наад захын хугацаа нь 3 жил байх ба энэ хугацааг сунгах эсвэл богиносгож болох бөгөөд АХБ-ны вэбсайтад мэдээллийг байршуулна. АХБ-ны вэбсайтад тавигдах нь Хар дансанд орох үр дагаврыг дагуулж болох юм.

Арга хэмжээ авах тухай шийдвэрийг мэдэгдэх

94. АТШБА нь АТШБА болон ШБХХ-ны зүгээс гаргасан арга хэмжээ авах тухай шийдвэр, түүний үндэслэл болон нөхцлийн талаарх мэдээллийг тухайн арга хэмжээний субъект болон хэрэгжүүлэгчгүйцэтгэгч байгууллага, АХБ-ны холбогдох бүх газар хэлтсүүдэд хүргүүлнэ. ШБХХ-ноос хориг арга хэмжээ оногдуулах шийдвэр гарах бүрт АТШБА-ны зүгээс холбогдох талуудад Шударга байдлын зарчмууд ба Аргачлал баримт бичгийн дагуу тухайн талаас Зарга мэдүүлэх эрхтэй талаар нь мэдэгдэнэ. АТШБА-наас ШБХХ-ны шийдвэрийг тухайн талд мэдэгдэх боломжгүй нөхцөлд энэхүү аргачлалд заасны дагуу тухайн шийдвэрийг АХБ-ны вэбсайтад байрлуулж олон нийтэд мэдээлнэ.

ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ

95. АТШБА нь Менежмент ба газар/албадуудтай хамтран ажиллаж зөрчил арилгах арга хэмжээг албадан хэрэгжүүлэх хяналтыг хангана.

ЗАРГА МЭДҮҮЛЭХ

96. АХБ-ны зүгээс хориг арга хэмжээ авагдсан тал АТШБА-наас ШБХХ-ны шийдвэрийг танилцуулснаас хойш 90 хоногийн дотор ШБХХ-ны шийдвэрийн эсрэг заргыг Хориг арга хэмжээг Давж заалдах Хороонд гаргаж болно. АТШБА-наас хориг арга хэмжээ авагдах болсон шийдвэрийг өөрийн буруутай бус байдлаас олж мэдээгүй бөгөөд хориг арга хэмжээ авагдсан тухайгаа сүүлд мэдсэн тал тодорхой хугацааны дотор зарга мэдүүлж болно. Бүх зарга нь бичгээр үйлдэгдэх ба АТШБА-ны шийдвэрийг эргэн хянуулах шалтгаануудыг товч бөгөөд ойлгомжтой дурьдаж АТШБА-наас ямар шалтгаанаар тухайн талтай холбоо барих боломж бүрдээгүй нөхцлийг шаардлагатай бол тайлбарлана.

97. 64-р заалтанд дурьдсан хориг арга хэмжээний үр дүнд оногдуулсан эрхийг хасах арга хэмжээнд зарга мэдүүлэх боломж байхгүй буюу АТШБА ба ШБХХ-ны шийдвэрүүд нь эцсийн шийд байна.

98. Хориг арга хэмжээг давж заалдах Хороо нь шинэ мэдээлэл нь доорхи нөхцөл байдлын улмаас танилцуулагдаж буй заргыг авч хэлэлцэнэ:

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

- i. АТШБА-ны зүгээс тайлбар шаардсан тухайн цаг үед тухайн мэдээлэл нь байхгүй эсвэл мэдэгдээгүй байсан, эсвэл тодорхой шалтгааны улмаас мэдэх боломжгүй байсан тохиолдолд
- ii. тухайн мэдээлэл нь тухайн хэрэгтэй холбоотой байж хориг арга хэмжээ оногдуулах шийдвэрт голлох нөлөө үзүүлэх бол.

99. Хориг арга хэмжээг давж заалдах Хороо нь үүсгэсэн заргад үндэслэн АХБ-ны оногдуулсан хориг арга хэмжээг бууруулах эсвэл чангатгаж болно. Хориг арга хэмжээг давж заалдах Хороо нь хувилбар арга хэмжээ болгож АТШБА-ыг тухайн хэргийг дахин хянан шалгаж ШБХХ-нд дахин хүргүүлэх шаардлага тавьж болно. Хориг арга хэмжээг давж заалдах Хороо нь тухайн зөрчлийн нөхцөл байдал болон хориг арга хэмжээний үргэлжлэх хугацаанаас хамааран 2 эсвэл 3 Дэд Ерөнхийлөгчөөс бүрдэнэ.²⁶ Ерөнхийлөгчийн зүгээс банкны удирдах ажилтнуудаас бүрдэх Хориг арга хэмжээг давж заалдах асуудал хариуцсан хорооны ажлын албыг хагсан жилээр томилон ажиллуулна. Давж заалдсан хэргийг хэлэлцэхэд оролцогч хорооны гишүүд сонирхлын аливаа зөрчилгүй эсэхэд хяналт тавьж ажиллах үүргийг уг ажлын алба хүлээнэ. Дэд Ерөнхийлөгчийн албыг хамгийн удаан хашиж буй хүн нь Хориг арга хэмжээг

²⁶ Хориг арга хэмжээний нөхцөл байдлаас болж 3 дэд ерөнхийлөгч шийдвэрлэх нөхцөлд нарийн бичгийн үзэж байгаагаар 3 дэд ерөнхийлөгчийг нэг дор уулзалт зохион байгуулах бололцоогүй үед Дарга нь газрын дарга болон орлогч даргыг хорооны 3 дагч гишүүнээр томилж болно.

ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ

давж заалдах Хороог даргална. АТШБА-ны дарга нь Хороонд багтах гишүүдийг нэр дэвшүүлэх ба уулзалтанд зөвлөх эрхтэйгээр оролцоно. Ерөнхий Консул мөн зөвлөх эрхтэйгээр оролцож болно. Зарим тохиолдолд АТШБА-ны ажлын алба зарга мэдүүлэх хэргийг татгалзах эрхгүйгээр Хориг арга хэмжээг давж заалдах Хороонд хүргүүлдэг ба тухайн асуудлыг 2 гишүүний нэг нь 3 дагч дэд ерөнхийлөгчийг заргыг шүүхэд байлцах ёстой гэж шаардаагүй нөхцөлд 2 дэд ерөнхийлөгчийн хүрээнд асуудлыг шийддэг.

100. Хориг арга хэмжээг давж заалдах Хороо нь өөрийн шийдвэрийг бүх гишүүдийн санал нэгдсэн нөхцөлд л гаргана. Хориг арга хэмжээг давж заалдах Хорооны дарга нь хорооны зүгээс нэгдсэн шийдвэрт хүрч чадахгүй нь гэж үзвэл Ерөнхийлөгчийн оролцоог эрэлхийлнэ. Ерөнхийлөгч Хориг арга хэмжээг давж заалдах Хорооны гишүүдийн байр суурийн зөрүүг арилгаж нэгдсэн шийдвэрт хүрэхэд нь туслах, харин шийдвэрт хүрэх боломж бүрдэхгүй бол өөрөө эцсийн шийдвэрийг гаргана.

101. Аливаа заргыг шийдвэрлэсэн Хориг арга хэмжээг давж заалдах Хорооны шийдвэр болон Хориг арга хэмжээг давж заалдах Хорооноос буцаж АТШБА-наас гарсан шийдвэрүүд нь эцсийн бөгөөд цаашид зарга мэдүүлэх эрхгүй шийдвэрүүд юм.

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

ЭРХИЙГ СЭРГЭЭХ

102. Эрхийг хассан хугацаа дуусмагц эрхээ хасуулсан талын эрх шууд сэргээгдэнэ гэж ойлгож үл болно. Эрхийг сэргээхийн тулд эрхээ хасуулсан талын хүсэлт шаардлагатай. Эрхийг сэргээлгэх тухай хүсэлтийг хүлээн авсан тохиолдолд АХБ нь энд заасан журмын дагуу эрхийг сэргээх, аль эсхүл \ж.нь тухайн тал эрх хасагдсан хугацаанд аль нэг өөр зөрчил үйлдсэн нь тогтоогдсон тохиолдолд\ хугацааг сунгах тухай шийдвэр гаргах зорилгоор АТШБА-ны оролцоотойгоор асуудлыг хянан хэлэлцэнэ.

103. Эрх сэргээлгэх хүсэлтийг

- i. бичгээр үйлдэж АТШБА-ны Даргад хаяглан хүргүүлнэ;
- ii. хориг арга хэмжээ авагдах болсон шалтгааныг дурьдах
- iii. АХБ-ны зүгээс эрхийг сэргээх ёстой гэж үзсэн үндэслэлээ хүргүүлэх.

104. АТШБА-наас эрх сэргээлгэх бүх хүсэлтийн магадлалыг нягталж эрх сэргээлгэх хүсэлт гаргасан талын шаардлага хангасан эсэхийг үнэлнэ. АТШБА-ны тооцож үзэх хүчин зүйлүүдэд дараах багтана. Үүнд:

- i. 79 (ii)-р заалтаар тогтоосон нөхцлүүдийг хангаж байгаа байдал;

ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ

- ii. хориг арга хэмжээ оногдуулсан шалтгаан (-ууд);
- iii. эрхийг нь сэргээх;
- iv. аливаа компаны менежмент ба өмчлөгчид гарсан өөрчлөлт ба компаны бүрэлдэхүүн хориг арга хэмжээнд хамрагдсан хэвээр байх эсэх;
- v. бизнесийн засаглалыг сайжруулах нотолж болохуйц механизм;
- vi. шударга байдлын зөрчлийг залруулах чиглэлд хориг арга хэмжээ авагдсан талаас санаачилсан үр дүнтэй захиргааны, иргэний эсвэл эрүүгийн механизм;
- vii. АХБ-наас хориг арга хэмжээ авагдсанаа дараа Шударга байдлын зөрчил гаргасаныг нотлох бусад мэдээлэл, үүнд бусад байгууллагуудаас оноосон хориг арга хэмжээ багтана
- viii. захиргааны хяналт болон мөрдөн байцаах ажиллагааны үр дүнгүүд.

105. Нягтлан хяналт болон эрэл сурвалжлах ажлын дүгнэлтэнд АТШБА нь тухайн талын эрхийг сэргээх эсэхийг тогтооно. Хэрэв АТШБА-наас тухайн талын эрхийг сэргээхгүй гэдгийг тогтоовол АТШБА-наас ШБХХ-нд тухайн нөхцөл байдлыг тайлбарласан тайланг бэлтгэж хүргүүлнэ. ШБХХ-ноос тухайн талын хууль ёсны байдлыг сэргээх эсвэл хориг арга хэмжээг тодорхой хугацаагаар сунгаж нэмэлт сунгасан хугацааны дараа тухайн тал эрхээ сэргээлгэх хүсэлтийг дахин тавьж болно.

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

106. АХБ-ны зүгээс АХБ-ны Авилгын эсрэг бодлогод тусгагдсан зөрчлийг гаргасан тал хийгээд түүний хамсаатан буюу ажил хэргийн холбоотой талуудад хориг арга хэмжээг хамаатуулан ноогдуулсан нөхцөлд эрхийг сэргээлгэх хүсэлтийн хувьд зөвхөн тухайн тал бус мөн түүний ажил хэргийн холбоотой талуудын АХБ-ны үйл ажиллагаанд оролцох эрхийг сэргээх асуудал мөн хэлэлцэгдэнэ.

107. Эрхийг сэргээлгэх хүсэлтэнд АТШБА бичгээр хариу өгөх ба үүнд хориг арга хэмжээг нэмэлт хугацаагаар сунгах шийдвэрийн үндэслэлийн хамт хүргүүлнэ. Хэрэв АТШБА-наас хориг арга хэмжээг нэмэлт хугацаагаар сунгах шийдвэр гарвал тухайн шийдвэрийн эсрэг заргыг зарга мэдүүлэх аргачлалын дагуу Хориг арга хэмжээг давж заалдах Хороонд гаргаж болно.

108. Зарим онцгой нөхцөлд (үүнд тодорхойгүй хугацаагаар эрх нь хасагдсан) АТШБА тухайн талын эрхийг сэргээх болон АХБ-ны үйл ажиллагаанд оролцох эрхгүй байгууллагуудын жагсаалтаас хасах эсэх шийдвэрийг гаргана. Нөхцөл байдлыг буруу шийдвэрлэгдэхээс урьдчилан сэргийлэх болон хориг арга хэмжээ авагдсан байгууллагуудын жагсаалтыг танах зорилгоор л АТШБА энэ арга хэмжээг хэрэгжүүлнэ. Тодорхойгүй хугацаагаар эрх нь хасагдсан талуудын хувьд хориг арга хэмжээний наад захын хугацаа болох 10 жилийн дараа л эрхээ сэргээлгэж болно.

ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ

109. Хориг арга хэмжээний эсрэг амжилттай давж заалдсан болон АТШБА-аас асуудлыг шударга бус шийдвэрлэсэн гэж үзсэн тохиолдолд холбогдох талын эрхийг сэргээнэ.

ОЛОН НИЙТЭД МЭДЭЭЛЭХ

110. 66, 71, 112 ба 113-р Бүлэгт зааснаас бусад тохиолдолд анх удаа хориг арга хэмжээ авагдаж байгаа талуудын жагсаалтыг олон нийтэд мэдээлдэггүй. Гэхдээ АТШБА-наас АХБ-ны эрхийг нь хассан талуудын жагсаалтыг нууцалдаггүй бөгөөд тухайн шийдвэрийг зайлшгүй мэдэх ёстой талууд болох АХБ-ны Захиралын зөвлөл, АХБ-ны үйл ажиллагаанд оролцож буй Засгийн газрын агентлагууд, олон улсын бусад хөгжлийн байгууллагууд, хоёр талт хандивлагч агентлаг зэрэг талуудад эдгээр мэдээлэл нээлттэй байдаг.

111. АТШБА-наас талуудад АХБ-ны үйл ажиллагаанд оролцох эрх зүйн бололцоогүй талаар мөн АХБ тэдний нэрийг олон нийтэд зарлан нийтлэхгүй бөгөөд харин хууль ёсны эрхгүй байх хугацаандаа АХБ-ны санхүүжилттэй, хариуцан хэрэгжүүлж буй болон дэмжлэгтэй үйл ажиллагаанд оролцох оролдлого хийх аваас хориг арга хэмжээний хугацааг сунгах тухайн этгээдийн нэрийг АХБ-ны вэбсайтанд байршуулах ба үүний үр дүнд олон улсын хэмжээнд хар дансанд оруулах хэлэлцээрийн дагуу хар дансны жагсаалтанд бичигдэнэ. АТШБА-наас 90-р заалтын (ii) ба (iii) дэд

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

заалтын дагуу эрхээ хасуулсан талуудын нэрийг мөн олон нийтэд зарлан нийтэлнэ. Зарга мэдүүлэх хугацаа дуусах эсвэл үүсгэсэн зарга нь хүлээн авагдахгүй буцаагдах хүртэл нэрсийг олон нийтэд зарлахгүй.

112. Хориг арга хэмжээ авагдах тал хориг арга хэмжээ авагдах болсон тухай шийдвэрийг хүлээн авсан хэдий ч авснаа хүлээн зөвшөөрөхгүй байх, шуудан харилцааг хүлээн авахаас татгалзах, эсвэл хаягаас нүүж АТШБА олохыг оролдсон ч олдохгүй байх тохиолдолд АТШБА ба ШБХХ тухайн талын нэр хаяг бүхий мэдээллийг олон нийтэд танилцуулж АХБ-ны вэбсайтад байршуулах шийдвэрийг гаргаж болох ба энэ нь Олон улсын хэмжээнд хар дансанд оруулах хэлэлцээрийн дагуу хар дансны жагсаалтад бичигдэхэд хүргэнэ.

113. Зарим онцгой тохиолдолуудад ШБХХороо шударга байдлын маш ноцтой зөрчил гаргасан талыг анх удаа зөрчил гаргасныг нь ч үл харгалзан оногдуулсан хориг арга хэмжээг олон нийтэд мэдээлнэ.

ОЛОН УЛСЫН ХЭМЖЭЭНД ХАР ДАНСАНД ОРУУЛАХ

114. Олон улсын хэмжээнд хар дансанд оруулах Хэлэлцээрийн дагуу Оролцогч байгууллагын хар дансанд оруулах шийдвэр нь доорхи нөхцлийг хангасан үед бусад Оролцогч байгууллагын хар дансанд оруулах шаардлагад нийцнэ:

ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ

- i. Шийдвэр нь хэсэгчилэн болон бүхэлдээ 2006 оны 9-р сарын 17 нд батлагдсан Залилан болон авилгаас урьдчилан сэргийлэх болон тэмцэх загварчилсан хүрээ баримт бичигт тодорхойлсон хориг арга хэмжээ авагдах заалт бүхий 1 ба түүнээс дээш зөрчилд (өөрөөр хэлбэл авилга, залилан, тулган шаардалт ба үгсэн хуйвалдах) үндэслэгдсэн байх;
- ii. Шийдвэрийг Хориг арга хэмжээ авч буй байгууллага зарлан нийтлэнэ;
- iii. Хар дансанд эхний удаад 1 жилээс дээш хугацаагаар оруулна;
- iv. Хэлэлцээрийн дагуу гарсан шийдвэрийг Хориг арга хэмжээ авч буй байгууллага хүлээн авч хэрэгжүүлсэн байх;
- v. Хориг арга хэмжээ авч байгууллагын шийдвэр нь тухайн хориг арга хэмжээг хэрэгжүүлж эхэлснээс хойш 10 жилийн хугацаанд гарсан байх;
- vi. Хориг арга хэмжээ авч буй байгууллагын шийдвэр нь тухайн улсын болон олон улсын форумын шийдвэрт үндэслэн гараагүй байх.

115. АТШБА-ны дарга бусад оролцогч байгууллагуудад Хэлэлцээрийн хүрээнд нийцэж буй АХБ-ны бүх хориг арга хэмжээ болон тэдгээрт орсон өөрчлөлтийг мэдээлнэ. Энэхүү мэдэгдэлд доорхи зүйлс багтана. Үүнд (i) хориг арга хэмжээ авагдсан талуудын нэрс ба

ШУДАРГА БАЙДЛЫН ЗАРЧМУУД БА УДИРДАМЖ

холбоо барих мэдээлэл, (ii) бодитоор үйлдэгдсэн хориг арга хэмжээ авагдсан зөрчил (-үүд) (iii) эрхийг хасах хугацаа ба түүнд орсон өөрчлөлтүүд. Олон улсын хар дансанд оруулах Хэлэлцээрийн дагуу хориг арга хэмжээг нийтэд мэдээлэх явц нь зөвхөн АХБ-ны вэбсайтад нийтлэгдсэн хориг арга хэмжээгээр хязгаарлагдах ба тухайн вэбсайтад нийтлэгдсэний дараа л мэдэгдэлийг хүргүүлэх ёстой. Эхэндээ холбоо барих боломжгүй байснаа сүүлд олдож холбоо тогтоосноос үүдэн АХБ-ны вэбсайтад байршуулсан хориг арга хэмжээний мэдэгдэлийг авах тохиолдолд юуны түрүүн тухайн хориг арга хэмжээг Хэлэлцээрийн заалтаас хасах, хориг арга хэмжээ хасагдахгүй нөхцөлд олон нийтэд зарлан нийтлэхгүй байх ёстой.

116. Олон улсын хар дансанд оруулах Хэлэлцээрийн дагуу Хориг арга хэмжээ авч буй байгууллагын зүгээс нэр нь тодорхойлогдож хориг арга хэмжээ авагдсан талыг л Олон улсын хар дансанд оруулдаг.

117. Олон улсын хар дансанд оруулах Хэлэлцээрт хамаарах хориг арга хэмжээг бусад оролцогч байгууллагын зүгээс оногдуулсан нөхцөлд АТШБА-ны дарга тухайн хориг арга хэмжээг хянан үзэж АХБ-ны зүгээс хар дансанд оруулах эсэхийг тогтооно. Хэрэв хар дансанд оруулах шийдвэр гарвал хар дансанд оруулсан тухай мэдээллийг АХБ-ны вэбсайтад зарлан нийтэлж хар дансанд орсон этгээдүүдэд зохих мэдэгдлийг хүргүүлнэ. АХБ-ны вэбсайтад байршсан өдрөөс эхлэн

ХОРИГ АРГА ХЭМЖЭЭ

хар дансанд оруулсан хугацаа тооцогддог учир бодит үргэлжлэх хугацаа нь Оролцогч байгууллагын зүгээс анхлан оногдуулсан хар дансанд байх хугацаанаас өөр байж болно. Олон улсын хэмжээнд хар дансанд оруулах шаардлагагүй бөгөөд АХБ-ны санхүүжилттэй үйл ажиллагаанд оролцох эрхтэй компани болон хувь хүний талаархи аливаа шийдвэрийг АТШБА-ны дарга батлуулахаар Ерөнхийлөгчид хүргүүлнэ.

118. Олон улсын хар дансанд орсон этгээдэд авах хориг арга хэмжээг Арга хэмжээ авагч байгууллага нэмсэн үед АХБ ч өөрийн Хар дансанд оруулах хориг арга хэмжээний шаардлагыг чангатгах буюу өөрчилнө.

Азийн Хөгжлийн Банкны тухай

АХБ-ны алсын хараа бол ядуурлаас ангид Ази, Номхон далайн бүс нутаг. Банкны эрхэм зорилго нь өөрийн гишүүн хөгжиж буй улс орнуудад ядуурлыг бууруулах, хүн амын амьжиргааг сайжруулахад чиглэнэ. Ази Номхон далайн бүс нутгийн хувьд ихээхэн ахиц дэвшил гарсан хэдий ч дэлхийн ядуу хүн амын дийлэнх нь тус бүс нутагт амьдарч байна. АХБ оролцоог хангасан эдийн засгийн өсөлт, байгальд ээлтэй тогтвортой хөгжил, бүс нутгийн интеграцчиллыг дэмжих замаар ядуурлыг бууруулахаар тууштай ажиллаж байна.

Манила хотод төвтэй АХБ нь 67 гишүүнтэйгээс 48 нь тус бүс нутгийнх. АХБ нь бодлогын дэмжлэг, зээл, хөрөнгө оруулалт, батлан даалт, буцалтгүй тусламж, техникийн туслалцаа зэрэг олон төрлийн арга хэрэгслээр дамжуулан өөрийн гишүүн хөгжиж буй улс орнуудад тусламж үзүүлэн ажилладаг.



АЗИЙН ХӨГЖЛИЙН БАНК

6 АХБ өргөн чөлөө, Мандалуён хот
1550 Метро Манила, Филиппин улс
www.adb.org

ISBN 978-929254929-9

